

УЛС ТӨР

⊖ Төв банкинд байсан "Капитал"-ын хөрөнгөөс татах боломж байгаагүй → 2

ЦАГ ҮЕ

⊖ Сэжигтэй хүмүүсийн шинжилгээний хариу сөрөг гарчээ → 6

ЭДИЙН ЗАСАГ

⊖ Хүнсний салбарын компаниудын ашиг тогтмол нэмэгдэж байна → 8

ZGM DAILY

⊖ FULL ENGLISH PAGE INSIDE → 20-21

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ



2020.02.17, ДАВАА-№032 (1311)

~ ИРГЭН БАЯН БОЛ УЛС БАЯН ~

₮1000, 24 НҮҮР

АЛТ 1,586.40 0.48%	ЗЭС 5,760.00 0.52%	ТӨМРИЙН ХҮДЭР 600.00 0.00%	НЕФТЬ 52.43 0.02%	ЧИНГИС БОНД 102.56	ХУРАЛДАЙ БОНД 108.18	ГЭРЭГЭ БОНД 102.38	САМУРАЙ БОНД 103.39	АМ.ДОЛЛАР 2756.26	ЮАНЬ 394.68	РУБЛЬ 43.44	ВОН 2.33
--------------------------	--------------------------	----------------------------------	-------------------------	-----------------------	-------------------------	-----------------------	------------------------	----------------------	----------------	----------------	-------------



Далайн боомтоор нүүрсээ экспортлох боломж бүрдсэн ч бэлтгэл хангалтгүй байна

fleetmon.com ©

→ 4

Саарал жагсаалт дахь Монгол Улсад хөрөнгө оруулахаас татгалзсаар байна



→ 9



МЭНДЧИЛГЭЭ



Монголын Ардчилал 30 нас хүрчээ. Өдгөө 30 настай залуус эрх чөлөөний үндэс суурин дээр төрж, өсч хүмүүжиж, боловсорч Хүний эрх, Эрх чөлөөг дээдэлсэн Ардчилсан Монгол Улсын иргэд болжээ. Ардчиллын 30 жилийн ололт амжилтыг дурдвал их билээ. Шинэ цагийн босгон дээр бид 500 сая ам.долларын эдийн засагтай, хүний хөгжлөөр хоцрогдсон, дэд бүтцээр ядмаг, иргэд нь өмчгүй, олон улсад зорчих эрхгүй, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжгүй, туурга тусгаар нэртэй ч нидэр дээрээ бусдаас хараат улс байв. Энэ хүнд бэрх цаг үед MoAX байгуулагдаж, 1990

оны хоёрдугаар сарын 18-ны өдөр анхдугаар чуулганаа хийж, Монголын Ардчилсан намыг тунхаглан зарлаж байв. Ингэж Монгол Улс 70 жил ноёрхсон нэг намын тогтолцоог халж олон намын тогтолцоонд шилжсэн юм. Үүгээрээ бид хүний өмчтэй байх эрхийг нээж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэг олон ургальч, хүмүүнлэг Ардчилсан нийгмийн суурийг тавьсан билээ. Өнөөдөр бид 14 тэрбум ам.долларын эдийн засагтай, иргэд нь өмчтэй, эрх чөлөөтэй, олон улсын хөгжил дэвшилтэй хөл нийлүүлэн алхдаг болжээ.

Энэ бүхэн зүгээр нэг олоогүй билээ. 1990 оны хахир хүйтэн өвөл хатуу цардмал талбай дээр жагсч, өлсч тэмцэж байж олж авсан эрх чөлөөгөө бид одоо ч хайрлаж, хамгаалж тордож байхгүй бол хуучин нийгмээ санагалзсан, хязгааргүй эрх мэдэлд шунасан эрт цагийн коммунистууд, өдгөө цагийн олигархи хөрөнгөтнүүд боломж сиймхий гарвал Ардчиллыг түлхэн унагаахад бэлхэн байгааг бид бүхэн харж, мэдэрч байна.

Тиймээс энэхүү түүхэн 30 жилийн босгон дээр Ардчиллаа улам бэхжүүлж, улс орноо улам илүү хөгжүүлэхийн төлөө Ардчилсан намын гишүүд, дэмжигч бүр хичээх хэрэгтэйг сануулахын ялдамд та бүхний ажил үйлс өөдрөг байж, эрүүл энх аз жаргал дүүрэн байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.


УИХ-ын гишүүн, Ардчилсан намын дарга *S. Erdene* Содномзундуйн Эрдэнэ

⊖ **Коронавирусээс авах сургамж буюу Цагаан сарыг ад үзэх шалтгаан** → 7

⊖ **Г.Ган-Эрдэнэ: Монголд сурдаг оюутнуудад атаархдаг байсан** → 14

Залуучууд ирээдүйдээ санаа тавьж, судалж, суралцдаг болсон нь анзаарагдсан.

⊖ **Уран нугараач гоо бүсгүй А.Бөртэ-Үжин** → 17



#1280 \$2.8 тэрбум

Виллиам Беркли, W. R. Berkley Corporation-ийн захирал, үүсгэн байгуулагч

Олон шинэ санааны араас бүү хөөцөлд. Нэгийг нь сонгоод бодитой болтол нь чадахаараа хичээ.



Өнөөдөр -7°C	Маргааш -9°C
-19°C	-19°C



УЛС ТӨР

ЗГМ:ТОДРУУЛГА

Төв банкинд байсан “Капитал”-ын хөрөнгөөс татах боломж байгаагүй

“Капитал” банкинд нэмж мөнгө байршуулаагүй

Б.Сэлэнгэ, ЗГМ сонин

Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөтэй холбогдуулан хуулийн байгууллага дээр хэд хэдэн хүнд хэрэг нээн шалгаж буй. Мөн Ардчилсан намын зүгээс тус сангийн хөрөнгийг эрсдэлтэй банкинд хийх зөвшөөрөл өгсөн хэмээн ХНХ-ын сайд асан Н.Номтойбаяр болон одоо тус салбарыг тэргүүлж буй сайд С.Чинзориг нарыг буруутгаад буй.

Уг асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзоригийн өгсөн тайлбарыг хүргэе.

“Капитал” банкны үйл ажиллагаа эрсдэлтэй болсон нь 2018 оны сүүлээр мэдэгдсэн гэсэн. Яагаад тухайн үед нь Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг татаж аваагүй юм бэ?

–Намайг сайдаар томилогдож ирэхэд арилжааны банкуудад тус сангийн 570 орчим тэрбум төгрөг байршсан байсан. Эдгээр хөрөнгийн 31 хувь буюу 238 тэрбум төгрөгийг “Капитал” банкинд байршуулсан байв. Хууль, зөрчиж зөвхөн нэг банкинд сангийн 31 хувийг байршуулсан нь энэ хөрөнгө эрсдэлд орох нөхцөлийг бий болгосон. Гэрээний нөхцөлийг биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд үл маргах журмаар хөрөнгөө татаж авна гэсэн заалт бий. Энэ заалтыг хэрэгжүүлэх



Гэрэл зургийг С.Батсайхан

үүднээс тухайн үед Нийгмийн даатгалын ерөнхий газраас “Капитал” банкинд мэдэгдэл хүргүүлж байсан. Мөн тухайн үед Монголбанкинд байршиж байсан “Капитал” банкны хөрөнгийг үл маргах журмаар Нийгмийн даатгалын санд буцаан төвлөрүүлэх арга хэмжээ авч өгөх хүсэлт хүргүүлсэн. Гэтэл Монголбанк “Энэ манай оролцох асуудал биш. Бидэнд тийм эрх байхгүй” гэдэг хариу өгсөн. Гэрээнд сангийн хөрөнгийг үл маргах журмаар татаж авна гэж заасан боловч энэ нь зөвхөн Нийгмийн даатгалын ерөнхий газар “Капитал” банкны хооронд

НАМАЙГ САЙДААР ТОМИЛОГДОЖ ИРЭХЭД АРИЛЖААНЫ БАНКУУДАД ТУС САНГИЙН НИЙТ 570 ОРЧИМ ТЭРБУМ ТӨГРӨГ БАЙРШСАН БАЙСАН.

хийгдсэн гэрээ байсан.

Өөрөөр хэлбэл, иргэний гэрээ учраас Монголбанкинд байршиж байгаа “Капитал” банкны

данснаас Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг татах эрх зүйн боломж байхгүй гэсэн хариу өгсөөр өнөөдрийг хүрсэн.

–Таныг “Капитал” банкинд мөнгө байршуулах гэрээг сунгасан гэж буруутгасан шүү дээ.

–2017 оны аравдугаар сард сайдаар томилогдож очиход “Капитал” банкны гэрээ дуусчихсан, 70 гаруй тэрбум төгрөгийн үлдэгдэл тус банкны харилцах дансанд байсан. Тухайн үед би энэ банкны байдал хүндэрч байгаа учраас гэрээ сунгахгүй гэсэн байдалтай 2018 оны тавдугаар сар хүртэл явсан. Дараа нь УИХ-ын НББСШУ-ны байнгын хорооны ажлын хэсэг “Капитал” банкны харилцах дансанд их хэмжээний мөнгө таван хувийн хүүтэй байршиж байна. Тиймээс мөнгөө татаж авч чадахгүй бол хүүгийн алдагдал үүрэхгүй байх нь зүйтэй. Мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуул” гэдэг чиглэл өгсөн учраас харилцах дансанд нь байсан 70 тэрбум төгрөгийг хадгаламж хэлбэрээр байршуулах гэрээ байгуулсан. Түүнээс “Капитал” банкинд мөнгө нэмж байршуулсан зүйл огт байхгүй.

–Одоо энэ мөнгийг олж авах ямар ажил хийж байна вэ?

–“Капитал” банкинд байршуулж байсан төрийн мөнгийг иргэдийн хадгаламжтай адилтгаж үзэх хүсэлт тавьсан. Хэрвээ энэ хүсэлтийг хүлээж авбал төсвийн хохирлыг барагдуулах дарааллыг өмнө нь оруулж шийдэх боломж бүрдэх юм. ■

ЗГМ: ТОВЧХОН

■ ХАРИЛЦАА

Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Б.Дорж, Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Т.Жанабазар нарыг томилж, Итгэмжлэх жуух бичгийг нь гардууллаа.

ТОМИЛГОО

3.Энхболдыг чөлөөлж, Ө.Шижирийг ЕТГ-ын даргаар ТОМИЛОВ

Ерөнхийлөгч Х.Баттулга “Албан тушаалаас чөлөөлж, томилох тухай” зарлиг гаргалаа.

Зарлигт “Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга 3. Энхболдыг өөрийнх нь хүсэлтийг үндэслэн 2020 оны хоёрдугаар сарын 14-ний өдрөөс үүрэгт ажлаас нь чөлөөлж, Өлзийхүүгийн Шижирийг мөн өдрөөс Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын албан тушаалд томилсугай” гэжээ.

Ө.Шижир нь Ерөнхийлөгчийн Тамгын газарт сүүлийн нэг жил гаруй хугацаанд ажилласан, Монголын хөлбөмбөгийн холбооны ерөнхий нарийн бичгийн даргын албыг хашдаг юм. Тэрбээр Ерөнхийлөгч Х.Баттулгыг Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдаар ажиллаж байхад нь сайдын ажлын албанд ажиллаж байв. Мөн Ардчилсан намын Үндэсний бодлогын хорооны гишүүн юм. ■

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020.02.17

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Тендер шалгаруулалтын нэр: Сантехникийн холбох хэрэгсэл болон бусад материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах /багцтай/.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР/ ГЭРЭЭНИЙ ДУГААР: УСУГ-БМ-2020-13

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендер оролцогчдоос сантехникийн холбох хэрэгсэл болон бусад материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тухайн тендер эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 /тавин мянган/ төгрөгний цахим тендерийн хураамж төлж оролцоно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 он тус бүрийн Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.

Сүүлийн 2 жилд буюу 2018, 2018 он тус бүрт ижил төстэй гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ.

Борлуулалтын орлого нь сүүлийн 2 жил /2018, 2019/ тус бүр тухайн багц тус бүрийн төсөвт өртгийн 100 хувиас дээш байх.

Нэг оролцогч тухайн тендерийн зөвхөн нэг

багцад санал ирүүлж болно. Хэрэв өөр багцад давхар санал ирүүлсэн тохиолдолд түүнийг үнэлэхгүй болохыг анхаарна уу.

Тендерийн хамт
Багц-1 748,000 /долоон зуун дөчин найман мянган/ төгрөг,
Багц-2 235,000 /хоёр зуун гучин таван мянган/ төгрөг,
Багц-3 1,593,000/нэг сая таван зуун ерэн гурван мянган/ төгрөгний тендерийн баталгаа тус тус ирүүлнэ.

Хүчинтэй байх хугацаа: 2020 оны 5 дугаар сарын 15-ны өдрийг дуустал.

Тендерийг 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө цахим системээр тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 10 цаг 30 минут-аас нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дотоодын давуу эрх тооцно.

Гадаадын этгээд оролцох эрхгүй.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токиогийн гудамж-5, өөрийн байр, Б.Лхагвасүрэн Утас: 70157018-123

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020.02.17

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Ажлын бээлий нийлүүлэгчийг сонгон шалгаруулах / багцтай/.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР/ ГЭРЭЭНИЙ ДУГААР: УСУГ-БМ-2020-06

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендер оролцогчдоос ажлын бээлий нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тухайн тендер эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 /тавин мянган/ төгрөгний цахим тендерийн хураамж төлж оролцоно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.

Сүүлийн 2 жилд буюу 2018, 2019 он тус бүрт ижил төстэй гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ.

Борлуулалтын орлого нь сүүлийн 2 жил /2018, 2019/ тус бүр тухайн багц тус бүрийн төсөвт өртгийн 100 хувиас дээш байх.

Нэг оролцогч тухайн тендерийн 1 багцад санал ирүүлнэ. Хэрэв 2 дахь багцад санал

ирүүлсэн тохиолдолд түүнийг үнэлэхгүй болохыг анхаарна уу.

Тендерийн хамт

Багц-1 295,000.00 /хоёр зуун ерэн таван мянган/ төгрөг,

Багц-2 1,660,000.00 /нэг сая зургаан зуун жаран мянган/ төгрөг,

Багц-3 935,000.00 /есөн зуун гучин таван мянган/ төгрөг,

Багц-4 395,000.00 /гурван зуун ерэн таван мянган/ төгрөгний тендерийн баталгаа тус тус ирүүлнэ.

Хүчинтэй байх хугацаа: 2020 оны 5 дугаар сарын 15-ны өдрийг дуустал.

Тендерийг 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө цахим системээр тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 10 цаг 30 минут-аас нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дотоодын давуу эрх тооцно.

Гадаадын этгээд оролцох эрхгүй.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токиогийн гудамж-5, өөрийн байр, Р.Батсүрэн Утас: 70157018-121

Ховдын цэнхэр хязгаараас тэмээчин хүү мэндчилж байна



Т.Намуунболор, ЗГМ сонин

Одоогоос зургаан жилийн өмнө цахим сүлжээнд ботгоо угжиж буй бяцхан малчин хүүгийн зураг тарж, олон хүний хайрыг татсан билээ. Тус зургийг Ховд аймгийн Зэгс сумын 90 жилийн ойн үеэр “Мөнгөтэй зочин” нэвтрүүлгийн хөтлөгч С.Баяр хальсандаа буулгасан юм. Ботгоо угжиж буй малчин хүү Ц.Тэмүүжин өдгөө Ховдын цэнхэр хязгаарт, тэмээн сүрэг дундаа торниж байна. Ботго, хүү хоёр цаг цагаар өсөж, танигдахааргүй том болжээ.

Миний ботго өндөр ат болсон

Бид зургийн эзэн бяцхан хүүтэй холбогдож, цөөн хором ярилцсан юм.

-Чамайг хэн гэдэг вэ?

-Намайг Цогбадрахын Тэмүүжин гэдэг. Би хоёрдугаар ангийн сурагч.

-Чи зургаа авахуулж байсан үеэ санадаг уу?

-Энэ зургийг авахуулж байсан үеэ сайн санадаг. Тэр үед би гурван настай байсан. Манай сумын 90 жилийн ойгоор хотоос ирсэн зурагчин ах авсан юм.

-Зөндөө том болжээ. Ээж, аавдаа тусалж байна уу?

-Би ботгонуудаа угжиж тусалдаг. Бас тэмээгээ тууж ирдэг. Манайх 20 тэмээтэй.

-Ботго нь одоо том тэмээ болсон уу. Чи юу гэж дууддаг вэ?

-Миний ботго зөндөө том болж, өндөр ат болсон. Би тэмээгээ “өндөр хүрэн” гэж дууддаг. Бас байнга унадаг.

-Миний дүү, том болоод ямар мэргэжилтэй болохыг хүсдэг вэ?

-Том болоод уяач болно доо. ■

55 жил ханилж, 12 хүүхэд төрүүлжээ

Монгол Улсад ижил нэртэй гэрлэсэн 360 хос байдаг. Мөн ижил өдөр төрсөн 1996 хос бий. Тэдний нэг болох Увс аймгийн Тэс суманд амьдардаг, нас сүүдэр 73 хүрч буй хоёр сайхан буурай Даваагийн Мягмар, Жамаагийн Мягмар нар 1948 оны тавдугаар сарын 3-ны өдөр мэндэлжээ. 55 жил ханилж буй тэднийг ёстой л заяаны ханиуд гэлтэй. Хоёр буурайгийн отгон охид нь ихэр бөгөөд анхны ачтай нь нас чацуу аж. Монголын мянга, мянган гэр бүлүүдэд үлгэр жишээ, өмөг түшиг болж буй сайхан гэр бүлтэй цөөн хором хөөрөлдсөнийг хүлээн авна уу.

-Сайн байна уу, сайхан өвөлжиж байна уу. Хоёр буурай минь нас сүүдэр хэд хүрч байна вэ?

Д.М: -Сайн байна уу, хүүхээ? Өвөө, эмээ хоёр нь нас сүүдэр 73 хүрч байгаа. Нутагтаа мал маллаж амьдарч байна даа.



-Хэдэн хүүхэд төрүүлж өсгөв?

Д.М: -12 хүүхэд төрүүлж, өсгөлөө. Долоон хүү, таван охинтой. Үр, ач олныг үзлээ.

-Та гэр бүлийн хүнтэйгээ анх яаж танилцсан бэ?

Д.М: -Бид саахалт айлын хүүхдүүд. Сургуульд хамт сурдаг байлаа. Дөрөвдүгээр ангиа төгсөөд мал дээр гарсан.

-Танай хөгшин сэтгэлээ яаж илчилж байв?

Ж.М: -Эмээ нь тулгамдаж байна шүү. (инээв) 16 настай, шинийн гуравны өдөр энэ айлын бэр болж ирээд 55 жил өнгөрчээ. Аав, ээж

танилцуулж, хувь тавиланг маань холбож байв. Томчууд л шийддэг байлаа шүү дээ.

-Захиа бичиж байв уу?

Ж.М: -Захиа бичнэ, бичнэ. Олон захиа өгдөг байсан.

-Үр хүүхдүүдээ юу гэж сургадаг вэ. Хүүхэд залуустаа хандаж ерөөл, сургаалиа хайрлахгүй юу?

Д.М: -Ажилсаг, хичээнгүй яваарай гэж сургаж ирсэн. Залуус, хүүхдүүд минь хоорондоо эвтэй найртай байж, ажил хөдөлмөртөө шамдаж, бусдад сайн сайхныг ерөөж яваарай. ■

Хөлбөмбөгийн үндэсний шигшээ баг ДАШТ-ий бэлтгэлээ Катарт хийнэ

Азийн хөлбөмбөгийн холбооны дэд ерөнхийлөгч А.Ганбаатар Африкийн супер цомын тэмцээнд оролцож буй. Тэрбээр энэ үеэр Катарын хөлбөмбөгийн холбоотой 2018 онд байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийг дүгнэн ярилцжээ. Манай улсын шигшээ багийн тамирчид ДАШТ-ий урьдчилсан шатны Тажикстан болон Японы шигшээ багуудын эсрэг хийх тоглолтын өмнө Катар улсад 14 хоногийн хугацаанд бэлтгэл хийхээр боллоо.



Мөн энэ үеэр МХБХ-ны маркетингийн баг Катарт дадлага хийж, Монголын спортын сэтгүүлчдийн

төлөөлөл ДАШТ-ий бэлтгэл ажилтай танилцах, сурвалжлах боломж бүрдсэн байна. ■

✎ П.Батбөх, ЗГМ сонин

Монголчууд бидэнд их далайг ашиглах, тээвэр хийх нь алсын мөрөөдөл мэт санагдавч тийм боломж бүрэн бий. Бидний хүрэх зорилт бол уул уурхайн бүтээгдэхүүнийг далайгаар тээвэрлэж, гуравдагч оронд хүргэх явдал. Цаашилбал хөдөө аж ахуйн түүхий эдийг ч олон улсад нийлүүлэх гарц юм. Түүхий эдээ экспортлох ганц гарцтай байх нь ямар эрсдэлтэйг цар тахлын улмаас хилийн боомтуудаа хаасан энэ өдрүүдэд хангалттай мэдэрч байна. Манай эдийн засагт голлох үүрэг гүйцэтгэдэг уул уурхайн бүтээгдэхүүний экспортын гарцууд хаагдахаар далайн тээврээр гуравдагч оронд хүргэх асуудал яах аргагүй хөндөгдөж байна.

Монгол Улсын төрийн далбааг 389 хөлөг онгоц ашиглаж байгааг харгалзан НҮБ-ын Ерөнхий ассамблейгаас манай улсыг далайн гүрэн мөн гэдгийг баталгаажуулж, далайд тээвэр хийдэг бүх орон хүлээн зөвшөөрсөн. Энэ бол холын далай бидэнд ойртсоны том нотолгоо. 2016 онд Олон улсын далайн байгууллагаас (ОУДБ) Монгол Улсын Далайн захиргаанд аудитын шалгалт хийж, үндэсний хууль тогтоомждоо олон улсын гэрээ, конвенцын заавал мөрдөх хэм хэмжээг тусгах зөвлөмж өгсөн юм. Үүний дагуу 2018 онд Засгийн газраас ерөнхий төлөвлөгөө боловсруулан далай ашиглахтай холбогдсон 29 гэрээ, конвенцод нэгдээд буй. Мөн УИХ-аар Далай ашиглах хуулийн шинэчилсэн найруулгыг батлахад бэлэн болжээ. Тус хууль хэрэгжсэнээр хөрш орнуудтай хийсэн дамжин өнгөрөх тээврийн хэлэлцээрүүд ч амилах учиртай.

Монгол Улсыг далайн гүрэн гэдгийг хүлээн зөвшөөрснөөр эргийн боомт ашиглах боломжууд ч нээгдсэн. **2017 онд Монгол-ОХУ-ын Засгийн газар хооронд төмөр замаар дамжин өнгөрөх тээврийн тарифын хэлэлцээрийг үзэглэж, 2018 онд баталгаажуулсан. 2014 онд өмнөд хөрштэй хэлэлцээр хийж тус улсын хилээр нэвтрүүлж буй уул уурхайн бүтээгдэхүүний дөрөвний нэгийг Хятадын төмөр замаар дамжуулан өөр оронд экспортлох зөвшөөрөл авсан.** Мөн ОХУ-ын болон БНХАУ-ын далайн боомтуудыг



⊕ “Эрдэнэс-Тавантолгой” ХК, ОХУ-ын “Фэско” групптэй хамтран нүүрсний терминал байгуулахаар ажиллаж буй нь уул уурхайн бүтээгдэхүүнээ далайгаар тээвэрлэж, гуравдагч оронд хүргэх бүрэн боломж бүрдсний илэрхийлэл юм.

Далайн боомтоор нүүрсээ экспортлох боломж бүрдсэн ч бэлтгэл хангалтгүй байна

Ерөнхийлөгчийн Японд нүүрс нийлүүлэх тохиролцоог биелүүлэх боломж ойрын жилүүдэд бүрдэхгүй нь ээ

ашиглах боломжийг нээгээд буй юм. Манайхаас илүү хөгжилтэй эх газрын Азербайжан, Казахстан зэрэг улс далайн боомт ашиглах бидний боломжид “атаархаж” байгааг энд дурдууштай.

Үүний зэрэгцээ Ерөнхийлөгч Х.Баттулга Владивостокт Дорнын эдийн засгийн V чуулганд оролцоходоо Японы Ерөнхий сайд Ш.Абэтэй уулзаж, Тавантолгойн нүүрсийг Японд нийлүүлэх тохироонд хүрсэн. Үүний дагуу “Эрдэнэс-Тавантолгой” ХК, ОХУ-ын “Фэско” групптэй хамтран нүүрсний терминал байгуулахаар төлөвлөсөн нь уул уурхайн бүтээгдэхүүнээ далайгаар тээвэрлэж, гуравдагч оронд хүргэх бүрэн боломж бүрдсний илэрхийлэл юм. Холын далай ойрын зорилтыг маань биелүүлэх ийм сайхан боломж бүрдсэн энэ

ТӨМӨР ЗАМЫН ТРАНЗИТ ТЭЭВЭР, ДАЛАЙН БООМТ АШИГЛАХ ЭРХ ОЛЖ АВСАН Ч ДОТООДЫН ХҮЧИН ЗҮЙЛС ДАЛАЙ АШИГЛАХ БОЛОМЖООС ХОЙШ ЧАНГААЖ БАЙНА.

үед “тултал” ашиглах нь зөв зам мөр гэдэг нь ч тодорхой. Гэвч манай улс хөлөг онгоцонд далбаагаа ашиглуулахаас өөрөөр далайг ашиглаж чадалгүй өдийг хүрлээ. Үүний гол буруутан нь монголчууд бид өөрсдөө юм. Далайн боомт ашиглахын тулд тэнд хүрэх дэд бүтэц, түүхий эдийн хангалтыг

бүрдүүлэх ёстой. Харин энэ чухал ажил манай улсад салан задгай байна. Өөрөөр хэлбэл, манай дотоод хүчин зүйлсээс шалтгаалсан доголдол далай ашиглах боломжийг маань хойш татаж буй юм.

Далайн тээвэрт угаасан болон коксжуулсан нүүрсийг тээвэрлэх журамтайгаас гадна тээвэрлэлтийн зардал өндөр гардгаас түүхий нүүрс үнэ хүрэхгүй. Мөн боомтод овоолго үүсгэх зорилгоор их хэмжээний нүүрс угаах шаардлага ч бий. Тиймээс манай улс нүүрс угаах, коксжуулах үйлдвэрийн хүчин чадлаа нэмэхгүйгээр далайн тээврээс ашиг олох боломжгүй. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын 72 хувийг нүүрсний экспорт эзэлж буй энэ үед нүүрс угаах үйлдвэрүүдийн

хүчин чадлыг нэмэхгүй байгаа нь далайн тээвэр хийх боломжийг шууд хумьж байна. Улсын хэмжээнд нүүрс угаах 14 үйлдвэр барьснаас хэдхэн үйлдвэр л угаасан нүүрс экспортолж буй нь туйлын чамлалттай бөгөөд харамсалтай. Тухайлбал, Тавантолгойн нүүрсийг угаах зорилгоор байгуулсан Шивээговийн нүүрс угаах үйлдвэр жилд 1.5 сая тонн, БНХАУ-ын Fu Sheng Import & Export компанитай хамтарсан үйлдвэр жилд 500 мянган тонн нүүрс угаажээ. Мөн 15 сая тонн нүүрс угааж, баяжуулах хүчин чадалтай “Энержи ресурс” ХХК-ийн үйлдвэр өнгөрсөн онд 4.5 сая тонн орчим, Нарийнсухайтад олборлолт хийж буй “Саусгоби Сэндс” ХХК дөрвөн сая тонн нүүрс экспортлохоор

[ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургалч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН
Ерөнхий эрхлэгч
Баатарын Дуламхорлоо
Зөвлөх
Шатарбалын Даваадорж
Орлогч эрхлэгч
Лхагважавын Сугармаа
Утас: 99903584

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Энхжаргал
Утас: 99901621

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба
Эдитор Б.Баяртогтох
Утас: 99901532

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581
99903578
99907843

ЦАХИМ ХУВИЛБАР

zgm.mn
ubinfo.mn

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
“Блю Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ДУГААРЫН УДИРДАГЧ

Л.Сугармаа

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА
Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал
✉ **INFO@ZASAG.CO**
Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

төлөвлөснөөс 800 мянган тонныг л гаргажээ. Тавантолгойг түшиглэсэн үйлдвэрүүд шинэ төмөр зам ашиглан

далайн эрэгт хүрэх боломжийг эрэлхийлж байгаа бол Нарийнсухайтын бүлэг ордыг ашиглагч компаниуд нүүрс угаах үйлдвэрээ барьсан ч төмөр замгүйгээс энэ боломжоос хасагдаж байна. Тэгэхээр эхний ээлжинд төмөр замын транзит тээвэр ашиглан далайн боомтод нүүрсээ хүргэх боломж Тавантолгойг тойрсон хэдэн компани, Шивээговийн нүүрс угаах үйлдвэрт л олдож байгаа юм.

Ерөнхийлөгч худалдан авагчийг “бэлтгэж”, Засгийн газрын түвшинд төмөр замын транзит тээврийн

эрх олж, далайн боомт ашиглах зөвшөөрөл авсан ч нүүрс угаах үйлдвэрүүдийн хүчин чадал бага, дэд бүтцийн бүтээн байгуулалт дутуугаас далай ашиглах боломж хойшилсоор байна. ■

Түүхий эд экспортлох ганц гарцтай байх нь ямар эрсдэлтэйг цар тахалтай холбогдуулан хилийн боомтуудаа хаасан энэ өдрүүдэд хангалттай мэдэрлээ. Тиймээс уул уурхайн бүтээгдэхүүнээ далайн тээврээр гуравдагч оронд хүргэх асуудал чухалд тооцогдож байна.

ЗГМ:ТОДРУУЛГА

С.Түвшинтөр: Далайн тээвэрлэлт хийх, менежмент хариуцах компаниуд бэлэн байна



Дээрх боломжийг бүрдэхээр хэрхэн ажиллаж буйг ЗТХЯ-ны Далайн захиргааны дарга С.Түвшинтөрөөс тодрууллаа.

-Далайн боомт ашиглах боломж бүрдсэн гэж ГХЯ үзэж байна. Харин танай байгууллага бэлтгэлээ хангасан уу?

-Алс Дорнод дахь далайн боомтуудыг ашиглахаар ОХУ-ын “ФЕСКО” групптэй хамтран терминал байгуулахаар ТЭЗҮ-ийг боловсруулж дууссан. Хууль эрх зүйн хувьд боомт ашиглах, далайн тээвэр хийхийн тулд НҮБ-аас баталсан 30 гаруй конвенцод нэгдэх ёстой. Манай улс дийлэнх конвенцод нэгдсэн учир боломж бүрдсэн.

-Энэ боломжийг ашиглахад одоо юу дутаж байна вэ. Боловсон хүчний хувьд хэр бэлтгэгдэв?

-Боомт ашиглахад цаг хугацааны болоод нүүрс угаах үйлдвэр, дэд бүтэц барих зэрэг дотоод хүчин зүйлсээс шалтгаалсан хүлээлт үүссэн. Боловсон хүчний хувьд Далайн захиргаанд Олон улсын

далайн байгууллагын (ОУДБ) дэргэдэх сургууль болон ОХУ, БНХАУ, БНСУ-д далайн мэргэжлээр суралцсан 26 хүн ажиллаж байна. Цаашдаа үндэсний хөлөг онгоцоор нүүрс тээвэрлэхийн тулд далайчид бэлтгэхээр зорьж байгаа. Хөлгийн туслах ажилтан, эмч, тогоочоос эхлээд ахмадыг хүртэл бэлтгэх шаардлагатай. Далайчдын холбооноос ойрын хугацаанд далайн хөлөгт ажиллах туслах ажилчдыг бэлтгэхээр болсон. Харин нарийн мэргэжлийн ажилтан, ахмадыг бэлтгэхэд хөрөнгө, хугацаа их шаардана.

МОНГОЛ УЛС НЭГ Ч ХӨЛӨГ ОНГОЦГҮЙ. ХӨВСГӨЛИЙН “СҮХБААТАР” ЧИРЭГЧ ЗАВИНД ТООЦОГДДОГ.

-Далайгаар нүүрс тээвэрлэхийн тулд манай улс өөрийн гэсэн хөлөг онгоцтой байх ёстой юу?

-Заавал хөлөг онгоцтой байх шаардлагагүй. Түрээсээр шийдэж болно. Далайд тээвэрлэлт хийх

компанийг дор хаяж таван хөлөг онгоцтой байхыг шаарддаг. Нэг хөлөг онгоцны дундаж үнэ 150 сая ам.доллар учраас манай улсад тийм боломж байхгүй, хөрөнгө оруулах бизнесмэн ч алга. Мөн дотоодод үйл ажиллагаа явуулж байгаа нэг ч хөлөг онгоц байхгүй. 360 гаруй завь л бий. Хөвсгөл нуурт тээвэр хийж байгаа “Сүхбаатар” гэхэд л чирэх зориулалтай завь шүү дээ.

-Далайн тээвэр хамтарч хийхээр БНСУ-тай хамтарсан “Монгол-Саммок” компанийг ашиглаж болохгүй юм уу?

-Уул уурхайн бүтээгдэхүүнийг гуравдагч оронд гаргахад БНСУ-ын далайн тээврийн туршлагыг ашиглахаар 2015 онд хоёр орны хооронд санамж бичиг байгуулсны дагуу “Монгол-Саммок”-ыг байгуулсан. Гэвч манай улс дэд бүтэц, нүүрс угаах үйлдвэр, лабораторигүйгээс тэр ажил гацсан. Хэрэв манайх далайн боомт дээр бүтээгдэхүүнээ хүргэх л юм бол тээвэрлэлтийн менежментийг хийх компани бэлэн байна. Мөн манай нүүрсийг далайгаар тээвэрлэх саналаа илэрхийлсэн 10 гаруй компанийн хүсэлт ирсэн. ■



УЛААНБААТАР
ХОТЫН БАНК

ХАДГАЛАМЖ БАРЬЦААЛСАН ЗЭЭЛ
ХАМГИЙН БАГА ХҮҮ

Цахим банкаар зээлээ ав

ЗГМ: ТОВЧХОН

■ ГЭМТ ХЭРЭГ

Гэрийн даалгавраа хийгээгүй гэсэн шалтгаанаар хүүгийнхээ амь насыг хохироосон хэргийг цагдаагийн байгууллагаас шалгаж байна. Аав нь 10 настай хүүхдээ гэрийн даалгавраа хийсэнгүй зодож, амь насыг нь хохироожээ.

■ ТОО

7950

Халдвараас урьдчилан сэргийлэх хүрээнд 7950 аж ахуйн нэгжид ариутгал хийжээ. Хоол үйлдвэрлэл, зах худалдааны төвийн 394 мянган ам метр талбайг ариутгасан байна. Мөн 58 мянган тонн хур хогийг цэвэрлэсэн байна.

■ ЗӨРЧИЛ

Зөрчлийн тухай хуулийн 5.1.1-д “Олон нийтийн газар, авто зам, орон сууцны орчны газар, гудамж, талбайд бие зассан, эсхүл нус, цэр, тамхины иш, хог хаясан бол хүнийг арван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” хэмээн заасан. Уг хуулийн дагуу 200 иргэнийг торгожээ.

■ МЭДЭГДЭЛ

Манай улс стратегийн хүнсний хэрэгцээгээ бүрэн хангах нөөцтэй байгааг ХХААХҮЯ, ШӨХТГ зэрэг холбогдох байгууллагаас мэдэгдлээ. Иймээс хүнсний бүтээгдэхүүн их хэмжээгээр нөөцөлж, үнэ хөөрөгдөхгүй байхыг худалдаа эрхлэгчид болон иргэдэд анхааруулаад байна.

Сэжигтэй хүмүүсийн шинжилгээний хариу сөрөг гарчээ

Эрүүл мэндийн байгууллагаас өгч буй зөвлөмжийг хатуу мөрдөхийг анхаарууллаа

✍ Б.Гантг, ЗГМ сонин

Эрүүл мэндийн яам COVID-19 вирусийн тархалтын талаарх мэдээллийг өдөр бүр хүргэж буй. Ням гаригт мөн ээлжит мэдээллээ хийлээ. Тус яамны Олон нийттэй харилцах, тандалт шуурхай удирдлагын хэлтсийн дарга Д.Нарангэрэл “Нийт өвчлөл 2800 тохиолдлоор нэмэгдэж, 68500 хүнд халдварласан байна. Одоогоор 1666 нас баралт бүртгэгджээ. Египетэд нэг тохиолдол бүртгэгдсэнээр дэлхийн 26 улсад тархлаа” гэв. ХӨСҮТ-ийн захирал Д.Нямхүү “Манай улсад хэд хэдэн сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн ч шинжилгээний хариу сөрөг гарсан. Одоогоор Завхан аймаг, Налайх дүүрэг, ХӨСҮТ-д гурван хүнийг тусгаарласан. Бүгдийнх нь шинжилгээний хариу сөрөг гарлаа” хэмээн мэдээлэл өглөө. Мөн Замын-Үүдэд хилээр орж ирсэн 103 иргэнийг зочид буудалд байрлуулж, ажиглалт хийж байгаа аж. Тэдний дунд байсан



📷 Гэрэл зургийг С.Батсайхан

халуурсан шинж тэмдэгтэй нэг иргэнийг тусгаарласан байна. Зарим хүн асуумж бөглөхдөө далайн захаар явсан, түүхий загас идсэн тухайгаа бичиж байгаа ч ЭМЯ-наас өгсөн зөвлөмжийг мөрдөхгүй байгаа нь ажиглагджээ. Тиймээс эрүүл мэндийн байгууллагаас өгч буй зөвлөмжийг хатуу мөрдөхийг анхааруулж байна. Завхан аймгийн Сонгино суманд сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнтэй холбоотойгоор Их уул суманд 24 цагийн

**УЛС ОРОН БҮР
КОРОНАВИРУСИЙГ
ЦАР ТАХЛЫН
ХЭМЖЭЭНД
ХҮРГЭХГҮЙН ТӨЛӨӨ
БОЛОЛЦООТОЙ
БҮХНЭЭ ХИЙХГҮЙ
БОЛ МАРГААШ
ОРОЙТНО.**

хяналтын пост ажиллуулж буй бөгөөд тус газраар дайрч

өнгөрдөг Увсын тээврийн хэрэгслүүдийг зогсоохгүй явуулж байна.

Түүнчлэн ДЭМБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Тедрос “Улс орон бүр коронавирүсийг цар тахлын хэмжээнд хүргэхгүйн төлөө бололцоотой бүхнээ хийхгүй бол маргааш оройтно” гэдгийг анхаарууллаа. Иймээс хүн бүр хариуцлагатай байж, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөхийг эрүүл мэндийн байгууллагаас сануулсаар байна. ■

мэдээ мэдээлэл

Хилчид төөрсөн иргэдийн амийг аварчээ

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутагт хүчтэй цасан шуурга болж, Дорноговь аймгийн Хатанбулаг сумын хоёр иргэн сураггүй алга болсныг хилчид олж, амийг нь аварлаа. Тодруулбал, Дорноговь

аймгийн Хатанбулаг сумын Сулин багийн иргэн Д.Наран, Б.Галбадрах нар 2020 оны хоёрдугаар сарын 13-ны өдөр малаа эргүүлэхээр гэрээсээ гараад сураггүй болсон мэдээллийг Хилийн 0168 дугаар

ангийн удирдлага авч, эрлийн ажиллагаанд оролцсон байна.

Тус ангийн хилийн албаны тасгийн дарга, хошууч Д.Доржпалам ахлагчтай багийнхан иргэн Д.Наранг Талын худаг нэртэй газраас

бээрсэн байдалтай олж анхны тусамж үзүүлжээ.

Мөн хилийн 0171 дүгээр салбарын хилчин, дэд түрүүч Л.Сэдэд, байлдагч Б.Пүрэвдорж нар Эрдэнэ-далай гэдэг газраас иргэн

Б.Галбадрахыг хоол хүнсгүй, эзэнгүй гэрт хоргодож байхад нь олж тусалжээ. Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлсэн тул иргэдийн биеийн байдал сайжирсан байна. ■

Хяналтаа чангатгана



Коронавирүсийн халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Ерөнхийлөгч цагаан сарыг тэмдэглэхгүй байх зарлиг гаргасан билээ. Иймээс Нийслэлийн онцгой комиссоос хяналтыг чангатгах гэж байна. Тус Комиссын дарга, Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан “Монгол Улсад коронавирүсийн халдвар илрээгүй ч бид санаа амарч болохгүй. Төр засгаас сар

шинийн баярыг тэмдэглэхгүй байх уриалга, зөвлөмж гаргасан, үүнд хяналт тавьж, иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлана. Хүн олноор цугладаг гэр болон амралтын газруудад хяналт тавина. Айл хэсэхгүй байх, аав ээжээ эрсдэлд оруулахгүй байхыг сануулъя. Нийслэлийн нутаг дэвсгэрийн бүх шатанд эрсдэлийг таслан зогсоож, шаардлагатай арга хэмжээг авна” хэмээв. ■

ТӨРИЙН БАНК
ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020 оны 02-р сарын 17

Тендер шалгаруулалтын нэр: Антивирүсны програм хангамжийн лиценз нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: ТБ/202001167

Төрийн банк нь эрх бүхий тендер оролцогчдоос Антивирүсны програм хангамжийн лиценз нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

• Тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn гэсэн цахим хуудсаар дамжуулан авах ба эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 /тавин мянган/ төгрөгийг холбогдох дансанд тушаан оролцоно.

• Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

• Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Борлуулалтын хэмжээ: 2018, 2019 он тус бүрийн борлуулалтын орлого нь тендер оролцогчийн санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх.

- Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2018, 2019 оны санхүүгийн тайланг ирүүлэх /Сангийн яамны И-Баланс цахим системд шивээгдэж баталгаажсан байх/

- Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: 2018, 2019 онуудын аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй антивирүсын программ хангамжийг нийлүүлсэн байна.

• Тендерийн баталгааны үнийн дүн: 4,600,000 /дөрвөн сая зургаан зуун мянга/ төгрөг байна.

• Тендерийг 2020 оны 03-р сарын 23-ны 10 цаг 00 минутаас өмнө www.tender.gov.mn гэсэн цахим хуудсаар дамжуулан ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй оролцогчдыг байлцуулан тендерийг тухайн өдрийн 10 цаг 20 минутад цахимаар нээнэ.

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Холбоочдын гудамж,
Төрийн банкны төв 2-р байр, Ерөнхий үйлчилгээний хэлтэс 2-р давхар, 202 тоот өрөө
Утас: 11-310103 /Дотуур дугаар: 4310/

Б.Энхжин, ЗГМ сонин

80 настай эмээгийн минь хувьд Цагаан сар хамгийн их догдлон хүлээдэг хэрнээ хамгийн их айдаг баяр нь. Мэдээж үр хүүхэд, ач зээ нараа тойруулан сууж, халуун ам бүлээрээ уулзалдах нь эмээгийн ганц хүсэл. Харин дуусагч өгдөггүй үргэлжилсэн их баяр эмээг багагүй ядраадаг юм. Бүр шинийн долоон, найман болчихоод байхад “Хөгшин дээрээ очиж золгохгүй бол алдас болно” гэсэн шүү юм ярьж архи сэнгэнүүлсэн залуус орж ирэх нь хөдөөд бол энгийн үзэгдэл. Олон зуун хүний хөлд дарагддаг болохоор бэлтгэх идээ будаа, бэлэг сэлтийг яриад ч яахав. Үйлчилгээнд дайчлагдаж буй охид, хүүхнүүд ёстой л борви бохис хийлгүй ажиллаж өдрийг авна. Тэднийг харахаар Д.Нацагдоржийн “Цагаан сар ба хар нулимс” өгүүлэгт гардаг Цэрмаа бүсгүй өөрийн эрхгүй санаанд ордог юм. Хамаатан саднаараа нийлж, элбэж дэлбэж байгаад л энэ баярын ард гардагсан. Харин Цагаан сарын дараа эмээгийн даралт ихсэж, эмнэлэг бараадах нь бараг ёс шахуу болжээ. Үнэнийг хэлэхэд 80 настай хөгшин байтугай залуус бид ч энэ нүсэр баярын дараа ядаргаанд орсноо мэдэрдгийг нуух юун.

Энэ жилд коронавирусийн халдварын улмаас улс орон даяар Цагаан сар тэмдэглэхийг албан ёсоор хорилоо. Гэр бүлийнхээ хүрээнд золгож болох ч үр хүүхдээ дагуулж, хамаатан саднаараа нийлж айл хэсэхээргүй болсон. Нэгэнт нөхцөл байдал амаргүй, аюулт өвчин тархах магадлал нэн өндөр учраас төрийн хууль журмыг дагахаас аргагүй. Анзаараад байхад Цагаан сар тэмдэглэхгүй байх энэхүү шийдвэрийг олон нийт тун баяртай хүлээн авлаа. Эсэргүүцэж дургүйцсэн хүн лав харагдсангүй. Өвчин тархахаас болгоомжилсон болохоор хориглох шийдвэрийг олон нийт дэмжсэн нь мэдээж.



Гэрэл зургийг С.Батсайхан

Коронавирусээс авах сургамж буюу Цагаан сарыг ад үзэх шалтгаан

Өвчин тархахаас болгоомжилсон болохоор Цагаан сар хориглох шийдвэрийг олон нийт дэмжсэн байх. Нөгөөтэйгүүр, иргэд энэхүү нүсэр баяраас үнэндээ залхжээ

Нөгөөтэйгүүр, иргэд энэхүү нүсэр баяраас үнэндээ залхжээ.

Цагаан сарын үеэр монголчууд 350 гаруй тэрбум төгрөгийг гадагш урсгадаг гэх статистик бий. Энэ мөнгөний дийлэнх нь урд хөршийг зорьж, оронд нь гарын бэлэг гэх хэрэгтэй хэрэггүй хог новш болон орж ирдэг. Үүнээс гадна дотооддоо урсгаж буй мөнгөн дүнг тооцвол бараг их наяд төгрөгт дөхөж очно. Энэ баяр өрхийн санхүүд ямар их дарамт

учруулдгийг эндээс харж болно. Ямар сайндаа л “монголчууд гурван сарын хүнсээ баярын гурав хоногт идэж дуусгадаг” гэх яриа гарах вэ дээ.

Нэгэнт хорьсон учраас энэ жил ихэнх айл Цагаан сар хийхгүй байх. Хийсэн зарим нь урьдынх шиг нүсэр зардал гаргахгүй нь тодорхой. Бид нэг жил тэмдэглэхгүй байж болж байгаа юм чинь хойшид ч арай даруухан, зардал чирэгдэл багатай хийдэг

болчихвол хэн хэндээ амар байхсан.

Энэ нь мэдээж биднээс л хамаарна. Шинэ хуучирчихаад байхад айл хэсэж дарамт учруулдаггүй, гарын бэлэг гэж Эрээнээс хог зөөдөггүй, залуу гэр бүл том ууц тавьж баярхахгүй, гарын бэлгээрээ хоорондоо өрсөлдөхгүй байхаас энэ бүхэн эхэлнэ.


Үнэндээ Цагаан сар жил ирэх тусам нүсэр болж, зардал

нэмэгдэж буй нь монголчууд бидний нэрэлхүү, барьцамтгай, бусдын дор орохгүйг хичээдэг хөгийн зангаас эхтэй. Тэднийх тавгийн идээгээ долоон давхар өрсөн байхад манайх юугаараа дутдаг юм, тэдний ууцнаас л томыг тавих юм шүү, хүний нүүр улайлгахааргүй бэлэг өгөх ёстой гэх мэтээр өөр хоорондоо өрсөлдсөөр байгаад одоо түүнийхээ ард гарч чадахаа больжээ.

БИД НЭГ ЖИЛ ЦАГААН САР ТЭМДЭГЛЭХГҮЙ БАЙЖ БОЛЖ БАЙГАА ЮМ ЧИНЬ ХОЙШИД Ч АРАЙ ДАРУУХАН, ЗАРДАЛ ЧИРЭГДЭЛ БАГАТАЙ ХИЙДЭГ БОЛЧИХВОЛ ХЭН ХЭНДЭЭ АМАР БАЙХСАН.

Монголчуудын цагаан сар тэмдэглэх байдлын талаар МУИС-ийн Нийгмийн ухааны сургуулийн багш С.Бямбадорж манай сонинд өгсөн ярилцлагадаа “Цагаан сар гэхээр хүмүүс яагаад дургүйцээд байна вэ. Учир нь энэ баяр орчин үеийнхээ шаардлагад нийцэхгүй болж байна. Тиймээс арай хөнгөн хэлбэрээр зохиодог болмоор байгаа юм. Монгол хүнд олны жишгийг дагана гэж аюултай зүйл байна шүү дээ. Сэтгэлгээний энэ саадыг даваад гарчихвал аяндаа цэгцрэх учиртай” хэмээж байв.

Цагаан сарыг нэг жил тэмдэглэхгүй байлаа гээд хохирох зүйлгүйг энэ жилийн үйл явдал харуулж байна. Харин монгол ёс заншил, өв уламжлалаа хадгалсан энэхүү баяраа хэт нүсэр тэмдэглэдгээ л болимоор байна. Үгүй бол тээршээж, ад үзэх хүний тоо жилээс жилд нэмэгдэх шинжтэй болжээ. ■




ТӨРИЙН БАНК
ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2020 оны 02-р сарын 17**
Тендер шалгаруулалтын нэр: **Серверийн антивирусийн програм хангамж нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: **ТБ/202001098**
Төрийн банк нь эрх бүхий тендер оролцогчдоос Серверийн антивирусийн програм хангамж нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

- Тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn гэсэн цахим хуудсаар дамжуулан авах ба эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр **50,000** /тавин мянган/ төгрөгийг холбогдох дансанд тушаан оролцоно.
- Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.
- Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - Борлуулалтын хэмжээ: 2018, 2019 он тус бүрийн борлуулалтын орлого нь тендер оролцогчийн санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх.
 - Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2018, 2019 оны санхүүгийн тайланг ирүүлэх /Сангийн яамны И-Баланс цахим системд шивээгдэж баталгаажсан байх/
 - Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: 2018, 2019 онуудын аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй антивирусийн программ хангамжийг нийлүүлсэн байна.
- Тендерийн баталгааны үнийн дүн: **7,200,000 /долоон сая хоёр зуун мянга/** төгрөг байна.
- Тендерийг 2020 оны 03-р сарын 19-ний 10 цаг 00 минутаас өмнө www.tender.gov.mn гэсэн цахим хуудсаар дамжуулан ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй оролцогчдыг байлцуулан тендерийг тухайн өдрийн 10 цаг 20 минутад цахимаар нээнэ.

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Холбоочдын гудамж,
Төрийн банкны төв 2-р байр, Ерөнхий үйлчилгээний хэлтэс 2-р давхар, 202 тоот өрөө
Утас: 11-310103 /Дотуур дугаар: 4310/



ТӨРИЙН БАНК
ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2020 оны 02-р сарын 17**
Тендер шалгаруулалтын нэр: **Сүлжээний тоног төхөөрөмж нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: **ТБ/202001060**
Төрийн банк нь эрх бүхий тендер оролцогчдыг **Сүлжээний тоног төхөөрөмж нийлүүлэх** байгууллагыг сонгох сонгон шалгаруулалтанд тендер ирүүлэхийг урьж байна.

- Тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn гэсэн цахим хуудсаар дамжуулан авах ба эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр **50,000** /тавин мянган/ төгрөгийг холбогдох дансанд тушаан оролцоно.
- Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.
- Тендер оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 2018 болон 2019 он тус бүрийн борлуулалтын орлого нь төсөвт өртөгөөс багагүй байна.
 - 2018 болон 2019 он тус бүрийн жилийн эцсийн санхүүгийн тайлан ирүүлнэ. /Сангийн яамны И-Баланс цахим системд шивээгдэж баталгаажсан байх/
 - 2018, 2019 он тус бүр санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй Сүлжээний тоног төхөөрөмж нийлүүлж, суурилуулж байсан туршлагатай байна.
- Тендерийн баталгааны үнийн дүн: **5,242,000 /таван сая хоёр зуун дөчин хоёр мянга/** төгрөг байна.
- Тендерийг 2020 оны 03-р сарын 24-ний 10 цаг 00 минутаас өмнө www.tender.gov.mn гэсэн цахим хуудсаар дамжуулан ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй оролцогчдыг байлцуулан тендерийг тухайн өдрийн 10 цаг 20 минутад цахимаар нээнэ.

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Холбоочдын гудамж,
Төрийн банкны төв 2-р байр, Ерөнхий үйлчилгээний хэлтэс 2-р давхар, 202 тоот өрөө
Худалдан авалт харууцсан мэргэжилтэн Утас: 11-310103-4310

ЭДИЙН ЗАСАГ

⊖ Саарал жагсаалт дахь Монгол Улсад хөрөнгө оруулахаас татгалзсаар байна

➔ 9

⊖ Тоон үзүүлэлтэд бус чанарт анхаарах хэрэгтэй

➔ 10

⊖ Сингапур вирусээс хохирсон эдийн засгаа дэмжиж эхэллээ

➔ 11

⊖ 3000 жилийн өмнөх эртний жорыг коронавирустэй өвчтөнүүдэд туршжээ

➔ 11

ЗГМ: ТОВЧХОН

■ АРИЛЖАА

24

Компани. Монголын хөрөнгийн бирж пүрэв гарагийн үнэт цаасны арилжаагаар 29 компанийн 439,755 ширхэг хувьцаа арилжлаа. Энэ өдөр 10 компанийн хувьцааны ханш өсөж, 17 компанийнх буурав.

■ ИНДЕКС

0.11

Хувь. ТОП 20 индекс 0.11 хувиар өсөж, зах зээлийн үнэлгээ 2.72 их наяд төгрөг боллоо.

■ ТАЙЛАН

20.1

Тэрбум төгрөг. “Түмэн шувуут” компани 2019 онд 20.1 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олсон байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 16 хувиар өссөн үзүүлэлт болжээ. Тайлант хугацаанд татварын дараах цэвэр ашиг нь өмнөх оны мөн үеэс 23.7 хувиар өсөж, 3.2 тэрбум төгрөг хүрсэн байна.

■ ХУДАЛДАА


1.2

Сая тонн. Mongolia Energy Corporation компанийн нүүрсний экспорт 2019 онд 70 хувиар өсөж, 1.2 сая тонн болжээ.

■ НОГДОЛ АШИГ

322

Сая төгрөг. “Гермес” компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 2019 оны цэвэр ашгаас нэгж хувьцаандаа 4.1 төгрөг буюу нийт 322 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон тараахаар болов. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг энэ сарын 28-ны өдрөөр гаргах бөгөөд ирэх сарын 15-ны өдөр Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах аж.



Хүнсний салбарын компаниудын ашиг тогтмол нэмэгдэж байна

✍ Б.Мөнх-Эрдэнэ, ЗГМ сонин

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниуд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуульд заасны дагуу хоёрдугаар сарын 10-ны дотор холбогдох байгууллагуудад хүргүүлэх үүрэгтэй. Энэ дагуу 199 компанийн 120 нь санхүүгийн тайлангаа одоогоор ирүүлжээ. Хуульд заасан хугацаанд үүргээ биелүүлээгүй буюу жилийн эцсийн санхүүгийн тайлангаа мэдүүлээгүй компаниудыг энэ сарын 24-ний дотор зөрчлөө арилгахыг Хөрөнгийн биржээс сануулжээ.

Тайлангаа ирүүлсэн компаниудын дийлэнх нь энэ онд ногдол ашиг хувьцаа эзэмшигчдэдээ олгохоо мэдэгдээд буй. Тэр тусмаа компаниудын борлуулалтын орлого 2018 онтой харьцуулахад нэмэгдсэн байна. Тухайлбал, бетон зуурмаг үйлдвэрлэгч, хөрөнгийн биржийн хоёрдугаар ангилалд бүртгэлтэй “Ремикон” компанийн борлуулалтын орлого 2019 онд 13.5 тэрбум төгрөг болж, 2018 онтой харьцуулахад 47 орчим хувиар өсжээ. Өнгөрсөн онд барилгын салбар идэвхжиж, төсвийн хөрөнгө оруулалт нэмэгдсэн нь ийнхүү эергээр нөлөөлсөн гэж тус компани дүгнэсэн байна. Зах зээлийн үнэлгээ нь 2.1 тэрбум төгрөгөөр

хэмжигдэх “Ремикон” тайлант хугацаанд 120.5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ. 2018 онд гадаад валютын ханшийн зөрүүнээс алдагдал хүлээж байсан бол 2019 онд 4.4 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Өөрөөр хэлбэл, валютын ханшийн эрсдэлээ удирдаж чадсан гэсэн үг.

Барилга, эрчим хүч, уул уурхай, харилцаа холбооны салбарт шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нийлүүлдэг “Техник импорт” компани 2019 онд 98.1 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллажээ. Энэ нь өмнөх оноос 4.4 хувиар өссөн үзүүлэлт. Тайлант хугацаанд тус компанийн цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар өсөж, 2.71 тэрбум төгрөгт хүрсэн байна. Үүнд борлуулалтын өсөлт голлон нөлөө үзүүлсэн гэж “Техник импорт” компани онцолжээ.

Харин уул уурхайн салбарт ажиллаж буй компаниудын ашиг, орлого 2019 онд нэг л базаахгүй үзүүлэлттэй байлаа. Тодруулбал, “Хөх ган” компани үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд оны эцэст алдагдлын хэмжээ нь 65 сая төгрөг болжээ. Дэлхийн зах зээлд төмрийн үнэ эрс унаж, төмрийн хүдрийн экспорт буурсан нь тус

компани алдагдалтай ажиллахад хөтөлжээ. Дээрх алдагдлын 55.3 сая нь удирдлагын зардлаас бий болсон байна. Олон нийтэд тайлангаа ил болгосон “Шивээ-Овоо” компанийн борлуулалтын орлого өнгөрсөн онд 55.7 тэрбум төгрөг байлаа. Гэвч 7.5 тэрбум төгрөгийн алдагдал хүлээв. Төвийн бүсийн эрчим хүчний нүүрсний хэрэглээний дийлэнх хувийг хангадаг тус компанийн хуримтлагдсан алдагдал жилээс жилд нэмэгдсэн хэвээр. “Шивээ-Овоо”-гийн нийт хувьцааны 90

хувийг төрийн өмчит “Эрдэнэс Монгол” эзэмшдэг.

Тус компанитай адилхан үйл ажиллагаа явуулах “Бэрх Уул” компанийн борлуулалтын орлого өнгөрсөн онд 1.3 тэрбум төгрөг болж, 2018 онынхтой харьцуулахад 13 хувиар өсжээ. Өнгөрсөн онд 58 мянган тонн нүүрс борлуулсан нь жилийн өмнөхөөс 6300 тонноор давсан байна. Харин энэ онд 60 мянган тонныг борлуулахаар төлөвлөжээ. Нэг зүйлийг онцлоход, 2019 онд гадаад валютын ханшийн зөрүүнээс хүлээсэн алдагдлын хэмжээ ойролцоогоор хоёр дахин буурсан байна. Компаниуд урьд өмнөх жилүүдтэй харьцуулахад валютын ханшийн эрсдэлийг урьдчилан тооцоолдог болсныг

эндээс харж болох юм.

Хөрөнгийн биржид бүртгэлтэй хүнсний салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниуд тайлангаа мөн танилцуулж эхэллээ. Тухайлбал, “Атар өргөө” компани өнгөрсөн онд 10.4 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан ба энэ нь 2018 онтой харьцуулахад 26 хувиар буурсан үзүүлэлт юм. Хэдий тийм боловч тайлант хугацаанд тус компанийн цэвэр ашиг 17 хувиар өсөж, 280 сая төгрөгт хүрсэн байна. Борлуулалтын өртгөө бууруулж зардлаа танасан нь нөлөөлсөн гэж тус компани мэдээлсэн юм. Харин “Талх чихэр” компани 54.7 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан бөгөөд энэ нь өмнөх оноос 17.7 хувиар өссөн үзүүлэлт болжээ. Тус компанийн цэвэр ашиг өмнөх онтой харьцуулахад 24.2 хувиар өсөж, 2.4 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Хөрөнгийн зах зээлд дээрх компаниудтай харьцуулахад шинэ бөгөөд хожуу хөл тавьсан “ЛэндМН ББСБ” 2019 оны цэвэр ашгаас нэгж хувьцаандаа 1.5 төгрөг буюу нийт 1.2 тэрбум төгрөгийг ногдол ашиг тараахаа мэдэгдлээ. 2019 оны цэвэр ашгаасаа хэчнээн компани хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг олгох мэдээлэл энэ одоо долоо илүү тодорхой болох юм. Учир нь энэ сарын 24-ний дотор компаниудын санхүүгийн тайлан олон нийтэд хүрсэн байх учиртай. ■

📷 Гэрэл зургийг С.Батсайхан

Саарал жагсаалт дахь Монгол Улсад хөрөнгө оруулахаас татгалзсаар байна

Дөрөвхөн зөвлөмжийг хангачихвал Саарал жагсаалтаас гарах боломжтой юмсан

Э.Батцэцэг, ЗГМ сонин

Өнгөрсөн оны аравдугаар сард Монгол Улс Зимбабве, Исландын хамт саарал жагсаалтад орж, харин мөнгө угаахтай тэмцэх дэглэмээ сайжруулсан Этиоп, Шри-Ланк, Тунис улс хасагдсан юм. Тэд FATF-ийн өгсөн зөвлөмжийн дагуу эрх зүйн орчноо сайжруулж, эдийн засгийн гэмт хэргийн илрүүлэлт, төсвийн бүрдүүлэлт, ил тод байдалдаа анхаарснаар олон улсын хараа хяналтаас “мултарч” чадсан. Тэгвэл саарал шугамын цаана “хоригдогсод” ямар өөрчлөлт хэрэгжүүлж байгааг сонирхлоо.

Исландын парламент нийтийн ашиг сонирхлын дагуу хөрөнгө хуваарилах зорилгоор байгуулагдсан, хил дамнансан үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудыг татварын албанд бүртгүүлэх ёстой гэсэн хууль гаргажээ. Ингэснээр манай ТББ-уудтай ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдүүд татвар төлдөг болов. Мөн тэд хилийн чанадаас, олон улсын байгууллагаас авдаг санхүүжилтээ ил тод мэдээлж, татварынхан тайланг хувийн хэвшилтэй ижил хугацаанд гаргадаг болжээ.

Түүнчлэн эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын явцад хураагдсан эсвэл царцаасан эд хөрөнгийг зарах эрх мэдлийг парламентад олгодог болов. Тодорхой нөхцөлд үүнийг шүүхийн шийдвэр гаргахаас өмнө хэрэгжүүлэхээр тусгажээ. Энэ мэтчилэн FAFT-ийн 40 зүйл шаардлагад хангалттай үнэлгээ авахын төлөө хууль тогтоох байгууллагаас эхлээд идэвхтэй ажиллаж байгаа аж.

Харин Зимбабве манайхтай нэлээн төстэй. Улс төрийн эрх мэдэлтнүүдийн хүрээнд авлигын үйлдэл “сүлжилдсэн” орон. ОУВС-гийн хяналтын баг тус улсад ажиллаж, саарал бүсэд шилжих эрсдэлтэйг анхааруулж байв. Хэрэв тус улсыг саарал жагсаалтад оруулбал түүнээс гарахын тулд дор хаяж гурван жил шаардлагатайг ч сануулж байв. Гэвч 2019 оны аравдугаар сарын 18-нд Зимбабве улсын мөнгө угаахтай тэмцэх ажиллагаа хангалтгүйд тооцогдон саарал жагсаалтад орсон юм. Олон улсын байгууллагууд тус улсад нягт ажиллаж байгаа бөгөөд,



Гэрэл зургийг С.Батсайхан

ДАРААХ ДӨРВӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХАНГАВАЛ СААРАЛ ЖАГСААЛТААС ГАРАХ БОЛОМЖТОЙ

FATF-ААС ӨГСӨН ЗӨВЛӨМЖ

1.3-р зорилт: “Хяналтын байгууллагууд санхүүгийн институцийг зохих ёсоор нь шалгах, хяналт тавих, зохицуулдаг байх”

2.7-р заалт: “Мөнгө угаахтай холбоотой хэрэг, үйлдлүүдийг мөрдөн шалгаж, гэмт хэрэгтнүүдэд үр дүнтэй, хийсэн хэрэгт нь дүйцэхүйц, давтан үйлдэхгүй болгохуйц шийтгэл ногдуулах”

3.8-р заалт: “Гэмт хэргийн орлого, хэрэгслийг хураан авах”

4.11-р заалт: “Нийтээр устгах зэвсгийг түгээхтэй холбогдсон хувь хүмүүс, хуулийн этгээд нь хөрөнгө мөнгө босгох, шилжүүлэх, хэрэглэхээс сэргийлэх”.

ШУУД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА

Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам /Мэргэшсэн нягтлан бодогчдын институт/, ХЗДХ-ийн яам /Монголын Нотариачдын танхим, Монголын хуульчдын холбоо/

Хууль сахиулах байгууллагууд /ЦЕГ, ТЕГ, АТГ, УЕПГ, Шүүх байгууллага/

Сангийн яам, Гаалийн ерөнхий газар

Гадаад харилцааны яам, Тагнуулын ерөнхий газар

техникийн үнэлгээний тайланг боловсруулжээ. Эрүүгийн гэмт хэрэг болон иргэний хэргийг шийдвэрлэх хуульд хэд хэдэн нэмэлт өөрчлөлт оруулж, прокурорын эрх мэдлийг нэмэгдүүлсэн байна. Хамаарал бүхий этгээдийн эд хөрөнгө, үнэт зүйлийг бүртгэж, гэмт хэргийн улмаас олж авсан хууль бус мөнгийг илрүүлэх чиглэлд ахиц дэвшил гаргажээ. Мөн “буруу гар”-аар мөнгө олсон нь

нотлогдвол тэнсэн харгалзах, дүйцүүлэн төлбөр төлөх ялыг хасаж, эд хөрөнгийг хурааж, заавал биеэр ял эдлүүлэхээр өөрчилсөн байна. Прокурорын байгууллагад хууль бусаар олж авсан өмчийг хурааж, хадгалах, засварлах, зарцуулах ажлыг зохион байгуулах эрх олгожээ. Энэ мэтчилэн зимбабвечуудын зүтгэлийг FATF-ийн үнэлгэний тайланд 11 үзүүлэлтийг ахиулсан дүн тавьсан байна.

Харин Монгол Улс саарал жагсаалтад орсноос хойш дөрвөн сарын хугацаанд юу амжуулав. Өнгөрсөн нэгдүгээр сард урьдчилсан тайлангаа гаргаж өгөх ёстой байсан ч энэ талаар мэдээлэл гарсангүй. Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудсанд өнгөрсөн аравдугаар сарын 28-нд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөө “зоосон”, тэр чигтээ. Учир нь хууль тогтоох дээд байгууллага эрх зүйн орчныг бүрэн бүрдүүлэхээс нааш биелэх боломжгүй тул мэдээлэх зүйл ч олдохгүй байна. Санхүүгийн зохицуулах хороо ч мөнгө угаахын эсрэг хэрхэн хяналт тавих тухай сургалт холбогдох байгууллагуудад зохион байгуулахаас хэтрэхгүй. Хамгийн гол нь FATF-ийн зөвлөмжийг хангахын тулд хууль эрх зүйн орчноо бүрэн бүрдүүлж өгөх шаардлагатай.

УИХ-аар Мөнгө угаах болон терроризмтой тэмцэх тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай зэрэг хуультай уялдан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг батлах ёстой байв. Гэвч гишүүдийн олонх дэмжээгүй тул унасан.

Эрүүгийн хуулийн 18.3 дахь хэсэгт, 300 мянган нэгж хүртэлх татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн бол

хүндрүүлсэн нөхцөлтэйгээр эрүүгийн хариуцлага тооцохоор зохицуулсан байв. “Татварын дансаа нууж, гурван тэрбум төгрөгийн орлого олоод улсад татвар төлөхгүй байхыг хууль ёсны үйлдэл гэж үздэг төрийн түшээд байна” гэж Х.Нямбаатар гишүүн тухайн үед шүүмжилж, саарал жагсаалтаас гарах боломжоос нэг алхам ухарч байна гэдгийг сануулж байв.

ЭНЭТХЭГ МОНГОЛЫН БИЗНЕСИЙН ЗӨВЛӨЛ ХАМТЫН АЖИЛЛАГААГА ЭХЛҮҮЛЖ, ТОДОРХОЙ ТӨСЛҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТОХИРОЛЦЖЭЭ. УУЛ, УУРХАЙ, МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ, БОЛОВСРОЛ БОЛОН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ДӨРВӨН ТӨСӨЛ ШАЛГАРУУЛЖ, ХӨРӨНГӨ ОРУУЛАХДАА ТУЛААД ГАЦСАН БАЙДАЛТАЙ ГУРВАН САРЫГ ЭЛЭЭВ.

Харин гадаад ертөнцөд манай улсыг Саарал жагсаалтад орсон тул хөрөнгө оруулахаас татгалзсаар ирлээ. Тухайлбал, Энэтхэг Монголын бизнесийн зөвлөл хамтын ажиллагаагаа эхлүүлж, тодорхой төслүүдийг хэрэгжүүлэхээр тохиролцжээ. Уул, уурхай, IT, боловсрол болон хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлэх дөрвөн төсөл шалгаруулж, хөрөнгө оруулахдаа тулаад гацсан байдалтай гурван сарыг элээв. Энэтхэгийн хөрөнгө оруулагчид саарал жагсаалтад орсон улстай хамтран ажиллахдаа болгоомжтой байхыг илүүд үзсэн аж.

Харин манай бизнесийнхэн хууль эрх зүйн орчноо сайжруулахыг хүлээж, ирэх дөрөвдүгээр сар хүртэл гэрээгээ цуцлахгүй харзнахыг хүсэв. Энэ мэтчилэн хувийн хэвшлийнхэн улсаа сааралтуулсан гол буруутан төрийн эрх баригчдын эс үйлдэхүйгээс шалтгаалан өсөж дэвжих үүдээ буй чулуугаар даруулсаар байна. ■

Б.Дашням, Шинжээч

Азийн хөгжлийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч Павит Рамачандрантай ярилцлаа. Тэрбээр “Монгол Улс эдийн засгаа төрөлжүүлж, сууриа тэлэх хэрэгтэй. Ингэхийн тулд ажлын байр бий болгодог хөдөө аж ахуй, аялал жуулчлал, жижиг дунд үйлдвэрлэл, сэргээгдэх эрчим хүч зэрэг салбартаа анхаарах хэрэгтэй” гэсэн юм.



Гэрэл зургийг С.Батсайхан

Тоон үзүүлэлтэд бус чанарт анхаарах хэрэгтэй

Өсөлтийг тогтвортой байлгахын тулд нэг хүчин зүйлээс хамаарал багатай байхад анхаарах хэрэгтэй



-Олон улсын хэмжээнд COVID-19-д анхаарал хандуулж байна. Ялангуяа, БНХАУ Азийн зах зээлийг донсолгож эхэллээ. Энэ нь Монгол Улсын эдийн засагт хэрхэн нөлөөлөхөөр байна вэ?

-Азийн хөгжлийн банк COVID-19-тэй холбогдуулан Монгол Улсын эдийн засагт учруулах нөлөөллийн хүчин зүйлсийг анхааралтай ажиглаж, боломжит нөлөөллийн суваг гурав байна гэж үзэж байна. Эхнийх нь худалдааны суваг. Одоогийн байдлаар БНХАУ руу чиглэсэн зэсийн баяжмалын тээвэрлэлтэд ямар нэгэн хязгаарлалт байхгүй байна. Гэхдээ **Хятадтай хил залгаа худалдаа, тээвэрлэлт, ложистикийн харилцаа, хамаарлаас шалтгаалаад суурь металлд учрах сөрөг нөлөө нь худалдааны төлөвт шууд нөлөөлөх болно.** Нөгөө нь санхүүгийн суваг юм. Логик харилцан хамаарлыг харахад түүхий эдийн үнийг бууруулах нөхцөл байдлууд эрсдэл дагуулж, хөрөнгө оруулагчдын сонирхлыг бууруулна. Тиймээс үүнийг анхааралтай ажиглаж байна. Харин сүүлийнх нь дотоодын эрэлт болон үйлчилгээний салбарт үзүүлэх нөлөөлөл юм. **Мах, гурил зэрэг хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнүүдэд**

МАХ, ГУРИЛ ЗЭРЭГ ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНД ИНФЛЯЦЫН ДАРАМТ УЧРУУЛАХ БАЙХ. ЭНЭХҮҮ ҮЗЭГДЭЛ АЛЬ ХЭДИЙН АЖИГЛАГДАЖ ЭХЭЛСЭН Ч ТҮЛШНИЙ ҮНЭ БУУРСАН НЬ НӨЛӨӨЛЛИЙГ СУЛРУУЛСАН.

инфляцын дарамт учруулах байх. Энэхүү үзэгдэл аль хэдийн ажиглагдаж эхэлсэн ч түлшний үнэ буурсан нь нөлөөллийг сулруулсан. Гэхдээ үүнийг цаашид анхааралтай ажиглах хэрэгтэй. Энэ мэтчилэн эдийн засгийн ерөнхий нөлөөллийг ажиглаж, судална.

-Та үүнийг нэг удаагийн, богино хугацааны нөлөөлөл гэж харж байна уу. Эсвэл Монголд урт хугацаанд нөлөөлөл магадгүй юу?

-Түрүүн хэлсэнчлэн үүнийг үргэлжлүүлэн ажиглах шаард-

лагатай. Бидэнд SARS-ын туршлага байгаа нь давуу тал болж байна. Монгол Улс бэлтгэлээ илүү сайн хангасныг Засгийн газрын хариу арга хэмжээ, бэлэн байдал, зохион байгуулалт, тайлагнах байдал зэргээс харж болно. Гэхдээ худалдаа, тээвэрлэлт, ложистикийн хэлхээ холбоо зэрэг хамааралтай байдлаас шалтгаалсан нөхцөл байдлыг сайтар ажиглах хэрэгтэй. Мөн БНХАУ-ын эдийн засгийн өсөлт тодорхой хэмжээгээр удааширна гэж таамаглаж байна. Тиймээс энэхүү цар тахал хэзээ оргилдоо хүрэхийг нь ажиглаж байна. Тэр хүртэл хэдэн сар ч болж магадгүй.

-Энэ онд сонгууль болно. Мөн ОУВС-гийн хөтөлбөр дуусна. Уг нь доноруудаас 5.5 тэрбум ам.долларын зээл авах байсан ч одоогоор энэ тоонд хүрээгүй байна. АХБ болон бусад донорууд ингэж хойш сууж байгаа нь юутай холбоотой вэ?

-ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр 2017 оноос хэрэгжиж байна. АХБ энэ хөтөлбөрт өмнө нь байгаагүй үүрэг оролцоотой ажиллаж байна.

Төсвийн нөхцөл байдалдаа анхаарч, шийдвэртэй арга хэмжээ авч чадсан Монгол Улсын Засгийн газрыг сайшаах хэрэгтэй гэж бодож байна. Ялангуяа, төсвийн алдагдал маш өндөр түвшинд хүрдэг байсан бол өнөөдөр төсвийн тэнцэл ашигтай гарах болсон. Мөн гадаад өрийг үлэмж хэмжээгээр бууруулсан. Ийм ахиц гарсанд маш их баяртай байна. Бид ОУВС, Дэлхийн банк зэрэг бусад түнштэйгээ хамтарч энэ төсөлд хувь нэмрээ оруулсан. Бид бодлогын зээл, төсвийн шууд дэмжлэг үзүүлэх ажлыг хариуцсан. Энэ хүрээнд нийгмийн хамгаалал, санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих чиглэлд нэлээд хэмжээний санхүүжилт олгосон. Мөн сүүлийн үед анхаарал татаж буй тэгш байдлын асуудалд анхаарсан. Бид түншүүдтэйгээ болон Засгийн газартай тогтмол харилцаатай байж, яриа хэлэлцээр хийж байна. **Ихэнх зорилт, тоон үзүүлэлтүүд биелсэн. Ганц үлдсэн асуудал нь банкны салбар.** Энэ асуудалд ямар ахиц гарч байгаа талаар Засгийн газартай хамтран

ажиллаж байна.

-АХБ болон бусад институт Монголын 2020 оны эдийн засгийн өсөлтийг 5-6 хувь байх таамаг дэвшүүлсэн. Одоо үүсээд байгаа нөхцөл байдал манай эдийн засгийн өсөлтөд хэрхэн нөлөөлөх бол?

-Зэсийн үнэ таамаглаж байсан түвшинд хүрэхгүй байж болзошгүй. Бусад суурь металлын үнийн төлөвт ч мөн нөлөөлж магадгүй. **Зөвхөн ДНБ-ий тоон үзүүлэлт дээр хэт их анхаарал хандуулах хэрэггүй. Үүнээс чухал зүйл бол өсөлтийн чанар, агуулга болон түүний тогтвортой байдал юм.** Монголын эдийн засаг ихээхэн хэлбэлздэг. Өсөлтийг тогтвортой байлгахын тулд нэг хүчин зүйлээс хамаарал багатай байлгахад анхаарал хандуулах хэрэгтэй. Хамгийн чухал зүйл нь эдийн засгийн төрөлжилт юм. Монгол Улс эдийн засгаа төрөлжүүлж, сууриа тэлэх хэрэгтэй. **Өөрөөр хэлбэл, адилхан ажлын байр бий болгодог хөдөө аж ахуй, аялал жуулчлал, жижиг дунд үйлдвэрлэл, сэргээгдэх эрчим хүч зэрэг салбартаа анхаарах хэрэгтэй.** Эдгээр салбарыг дэмжиж, хөгжүүлэхэд АХБ бэлэн байгаа.

-Зүүн хойд Азийн бусад орон эдийн засгаа төрөлжүүлж байна. Манай улс хөгжлөөрөө эдгээр орны ард хоцорч, зөвхөн нийлүүлэгч орон болох эрсдэл байна уу?

-Монгол Улсад хоёр том зах зээлтэй хил залгаа оршдог. Төв Азийн бүс нутагтай холбогдохоос гадна Япон, БНСУ-д экспорт хийх боломж байна. Монгол Улс эрчим хүчний салбарт үүнийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. **Байгалийн баялгаас олж буй орлогоо зөв зохистой зарцуулж, хуваарилалт зөв хийх нь сорилт боллоо.** ХАА-н бизнес, ялангуяа боловсруулах үйлдвэрлэлд анхаарах хэрэгтэй. Үнэ цэнийн хэлхээг бүрдүүлэгч сигментүүдийн хоорондын холбоо, ажлын байр бий болгох бололцоо маш чухал. Бид аялал жуулчлалын салбарт анхаарч ажилладаг. Эдгээр ажлыг зөв хэрэгжүүлбэл Монгол Улс ирэх жилүүдэд дунджаас дээш орлоготой орнуудын тоонд орж чадна. ■

БАРИЛГА

“Ремикон” ХК-ийн борлуулалтын орлого ₮13.5 тэрбум болов

Т.Элиса, Шинжээч

Монголын Хөрөнгийн биржийн II ангилалд бүртгэлтэй “Ремикон” ХК-ийн борлуулалтын орлого өнгөрсөн онд 13.5 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 47 орчим хувиар өсжээ. 2019 онд барилгын салбар идэвхжиж,

төсвийн хөрөнгө оруулалт өссөн нь ийнхүү эергээр нөлөөлсөн гэж тус компани дүгнэсэн байна.

Үүнээс гадна, томоохон зээлдэгч нартайгаа тохиролцож, зээлийн бүтцээ өөрчилсөн нь жилийн хүүгийн зардлаа хоёр дахин бууруулж чаджээ. 2018 онд гадаад

валютын ханшийн зөрүүнээс алдагдал хүлээж байсан бол 2019 онд 4.4 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Өнгөрсөн оны эцэст цэвэр ашиг нь 120.5 сая төгрөг болж, 2018 оныхоос 22 хувиар буурчээ. Тус компанийн зах зээлийн үнэлгээ нь 2.1 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байна. ■

ХЭРЭГЛЭЭ

\$5.4 саяыг шоколад болон какаоод зориулжээ

Өнгөрсөн сард Монгол Улс нийт 33 сая ам.долларын хүнсний бэлэн бүтээгдэхүүн импортолжээ. Үүнээс 5.4 сая орчим ам.доллар буюу 16.3 хувийг нь шоколад болон какао агуулсан бүтээгдэхүүн бүрдүүлсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс, 19 орчим хувиар өссөн дүн юм.

Хятадад коронавирусийн халдвар гарч эхэлснээс хойш нунтаг какаоны үнэ 19.5 хувиар өсөж, 2900 ам.доллар даваад байна. Харин цаашид Азийн томоохон нийлүүлэгч орнуудын экспортод нөлөөлбөл уг түүхий эдийн үнийг буурна гэж Rjo Futures таамаглажээ. ■

Сингапур вирусээс хохирсон эдийн засгаа дэмжиж эхэллээ

Синтия Ли

Сингапурын Засгийн газар коронавирусыг эдийн засагт учрах хохирлыг нөхөхийн тулд төсвийн хүчтэй дэмжлэг үзүүлэхээр төлөвлөж эхэллээ. Энэ нь тус улсын төсвийн алдагдлыг сүүлийн 20 жилд байгаагүй хэмжээнд хүргэнэ гэж шинжээчид таамаглаж байна. Тухайлбал, дөрөвдүгээр сарын 1-нээс эхлэх төсвийн жилийн алдагдал ДНБ-ий 1.5 хувьтай тэнцэхээр байгаа нь 2001 оны санхүүгийн жилд 1.7 хувь байсантай ойртож очих юм. Энэ оны эхээр халдвар

дэгдэхээс өмнө ч Сингапур худалдааны дайнд хохирсон бизнестээ дэмжлэг үзүүлэхээр бэлтгэж байв.

Хот улсад одоогийн байдлаар коронавирусийн 60 тохиолдол бүртгэгдсэн ба өдөрт 20000 жуулчин алдаж байгаа тооцоо гарчээ. COVID-19 өвчин 2003 оны SARS-аас илүү эдийн засгийн үр дагавартай байгааг тус улсын Ерөнхий сайд Ли Сиен Лун мэдэгдсэн. **Өвчлөлийн тархалт ба хүндрэлээс шалтгаалан коронавирус тус улсын ДНБ-ий өсөлтийг 0.5-1.0 хувиар доош татаж магадгүй.** Даваа гарагт нийтлүүлж буй дөрөвдүгээр улирлын тайлангаас үзэхэд



өнгөрсөн оны 0.7 хувийн өсөлтөд хүрэхгүй гэж тооцжээ. Citigroup банкны таамгаар дэмжлэгийн багцад 503 сая ам.доллар төлөвлөсөн нь тээвэр, аялал жуулчлалаас гадна бусад салбарт мөн хүртээх боломжтой. Уг нь SARS-ын үед үүнээс гурав дахин бага

хөрөнгө зарцуулж байв. Энэ онд Сингапурт сонгууль явагдах учир Засгийн газар дэмжлэгээ өргөн хүрээг хамруулах бодолтой байна. Сангийн сайд Хен Сви Кит

мягмар гарагт парламентад төсвийн саналаа оруулахаар бэлтгэж буй. Сингапур дотоодын жижиг ба дунд бизнест төсвийн бодлогоо зориулдаг учир шинэ төсвөөс тэд хамгийн их ашиг хүртэх байх гэж Bloomberg-ийн шинжээчид дүгнэв. ■

3000 жилийн өмнөх эртний жорыг коронавирустэй өвчтөнүүдэд туршжээ



Bloomberg News

Хятадын эртний уламжлалт эмийг коронавирусийн халдвартай өвчтөнүүдэд ашиглаж байгааг мэдээлжээ. Уханийн эмнэлэгт уламжлалт ба өрнөдийн анагаах ухааны эмийг хослуулан ашиглаж буй тухай Хубэй мужийн Эрүүл мэндийн хорооны шинэ дарга Ван Хешен ярьжээ. Түүний

хэлснээр уламжлалт эмийг тус мужид батлагдсан халдвартай өвчтөнүүдийн талаас илүүд өгсөн байна. **Ноён Ван “Бидний хүчин чармайлт сайн үр дүнд хүрсэн” гэсэн боловч нарийн зүйл мэдээлсэнгүй.**

Хубэй мужид ардын эмчилгээний 2200 эмч очсон аж. Хятадад 1523 хүний аминд хүрч, 66500 хүнд халдварлаад буй вирусийн

эсрэг буюу урьдчилан сэргийлэх эм одоохондоо батлагдаагүй байгаа. Шинэ вирус дэгдээд удаагүй боловч ямар нэгэн эмчилгээ, эмийн тухай мэдээ гарах бүрд хүмүүст найдвар төрүүлж буй. Gilead компанийн туршилтын эмийг анх эмч нар хэрэглэж эхэлсэн агаад үр дүнг нь тооцоход хугацаа хэрэгтэй байгаа юм. ■



Оростой энхийн тохиролцоонд хүрэх боломж нээгдсэн гэжээ

Илья Архипов

Украины Ерөнхийлөгч Владимир Зеленский Кремлийн шинээр томилогдсон төлөөлөгч энхийн дохио өгч буй учир **Оростой сөргөлдөөнөө зогсооход бэлэн байгаагаа мэдэгджээ.** Тэрбээр Мюнхений бага хуралд хэлсэн үгэндээ “Ерөнхийлөгч болсон анхны өдрөөс би дайныг хүсэхгүй

гэдгээ мэдэгдсэн. Гэвч одоо үүнийг зогсоох ёстой” гэжээ. Кремль прагматик бодлоготой улстөрч Дмитрий Козакт Украины асуудлыг хариуцуулахаа өнгөрсөн долоо хоногт мэдэгдсэн. Өмнө нь хатуу байр суурьтай гэгддэг Владислав Сурков Украины арми ба Оросын дэмжлэгтэй салан тусгаарлагчдын мөргөлдөөний асуудалд Москваг төлөөлж байсан юм. ■

Өмнөд Солонгос Токиод экспортын шаардлага тавив



Өмнөд Солонгосын Гадаад хэргийн сайд Кан Киунва “Япон улс хагас дамжуулагчийн эд ангийн импортод тавьсан хязгаарлалтаа нэн даруй зогсоох арга хэмжээ авах ёстой” хэмээн мэдэгдлээ. Тэрбээр Мюнхений бага хурлын үеэр Японы сайд Тошимицу Мотеигитэй уулзахдаа энэ талаар сануулжээ. Өнгөрсөн онд Токио Өмнөд Солонгосыг итгэмжит түншийн

жагсаалтаасаа хассан тул Сөүл хагас дамжуулагч ба дисплей үйлдвэрлэл экспортлоход хүндрэл учирсан юм. 1910-1945 онд Японы эзэнт гүрэн Солонгосын хойгийг колоничилж байхдаа Японы компаниуд солонгосчуудын хөдөлмөрийг мөлжиж байсандаа нөхвөр олгох ёстой гэх маргааны улмаас Ази дахь АНУ-ын гол холбоотой хоёр улсын харилцаа хурцадсан юм. ■

КОМПАНИОН

49 жилийн өмнө байгуулагдсан Samsung Electronics компани өнөөдөр 300 тэрбум долларын үнэлгээтэй, 300 мянган ажилтантай, дэлхийн хамгийн том электроникийн компани болон өргөжжээ. Солонгос залуучууд Өмнөд Солонгосын эдийн засгийн гайхамшигийг бүтээлцсэн энэ компанид ажиллахыг мөрөөдөж хүүхэд наснаасаа бэлтгэдэг. Монгол Улсын төгрөгийн ханш долларын эсрэг тасралтгүй суларч байхад Солонгосын воны ханш чанга байдгийн учир юу вэ. Samsung Electronics жил бүр хэдэн арван тэрбум долларын экспорт хийж улсынхаа эдийн засагт хувь нэмрээ оруулдаг.

Хэдэн жилийн өмнө нэгэн яаманд ажилладаг найз маань ажилдаа сэтгэл ханамжгүй байгаагаа яриу. Би ч хувийн сектор орж надтай хамтарч ажиллах санал тавилаа.



Гэтэл баруунд магистрийн зэрэг хамгаалсан, чамгүй туршлагатай найз маань нэг л эргэлзээд байгааг нь би мэдээд лавшруулж асуусан юм. Тэр хэсэг бодолхийлснээ “Компанид ажиллавал хүүхэд насны мөрөөдлөөсөө ухрах гээд байна аа. Улс орныхоо хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулж чадахгүй болно шүү дээ” гэж хэлсэн юм.

Мань хүн улс орны хөгжил дэвшилд компаниуд ямар ч үүрэггүй, харин яаманд том төслүүд хөдөлгөөд байж болдог гэж боджээ. Би улс орны хөгжил дэвшлийг компаниуд бүтээ-

дэг тухай тайлбарлаж ярьсан боловч найз маань огт итгэхийг хүсээгүй юм. Ерээд оны үед бид сагс тоглож, байрны подвалд байрлах ундааны цехээс 50 төгрөгийн гэх ундааг авч булаацалдан залгилдаг байж билээ. Хүн бүр санаж байгаа байх.

Одоо бодоход эрүүл ахуй, ариун цэврийн ямар ч шаардлага хангаагүй, ямар бодис хольж найруулсан нь мэдэгдэхгүй аюултай хүнс байж. Гэнэтхэн л “150” гэх реклам Монголын нийгмийг цочроож, 150 төгрөгийн кока колаг Монголд үйлдвэрлэж, 50 төгрөгийн ундаа зардаг

ӨНӨӨДӨР ХӨДӨӨНИЙ МАЛЧИН ХОНИО ХАРИУЛАНГАА ХОТОД СУУГАА ХҮҮХДЭДЭЭ МОБАЙЛ БАНКААР МӨНГӨ ШИЛЖҮҮЛЖ БАЙНА. ГАЙХАМШИГТАЙ БИШ ГЭЖ ҮҮ. ЭНЭ БОЛ ДЭЛХИЙН ШИЛДЭГ ТЕХНОЛОГИЙГ ХӨРӨНГӨ ГАРГАН БАЙЖ НУТАГШУУЛСАН ҮҮРЭН ХОЛБООНЫ КОМПАНИУД, БАНКУУДЫН ГАВЪЯА.

подвалын цехүүд бүгд үгүй болсон түүхтэй. Одоо бид ямар ч байсан дэлхийн стандартад нийцсэн ундаа уухтайгаа болсон. Мөн өнөөдөр хөдөөний малчин хонио хариулангаа хотод суугаа хүүхдэдээ мобайл банкаар мөнгө шилжүүлж байна. Гайхамшигтай биш гэж үү. Энэ бол дэлхийн шилдэг технологийг хөрөнгө гарган байж нутагшуулсан үүрэн холбооны компаниуд, банкуудын гавъяа.

Яг үүнтэй адилаар дэлхийн стандарт болсон KFC, Burger King, CU, Circle K гэх мэт сүлжээ манай улсад стандартад нийцсэн хоол хүнс, үйлчилгээгээ үзүүлж эхэллээ. CU, Circle K дэлгүүрээр ороход худалдагч залуус сайхан боловсон харьцаж, сэтгэл ханамж өгч байна. Тэд залуусыг маань сургаж хүмүүжүүлж байна.

Энэ мэтчилэн өнөөдрийг хүртэл компаниуд л Samsung-тай адилаар монголчуудад шилдэг үйлчилгээ, бүтээгдэхүүнийг авчирч, татвар төлж, залуусыг хөгжүүлж, доллар оруулж байна. Орчин үеийн хүн төрөлхтөнд хөгжил дэвшлийг хувийн компаниуд л авчирсан.

Банкууд, төмөр замын компаниуд, үйлдвэрүүд, Tesla, Google, Coca-Cola өнөөгийн дэлхийг бүтээсэн юм. Монголын хөгжил ч үүнээс гажихгүй. Тийм учраас бизнесмэнүүдийн нуруун дээр хүнд ачаа ирж байна. Бизнесмэн та өөрийн ажилтнуудад ажлынх нь ач холбогдол, улс орны өмнө хүлээж буй үүрэг хариуцлагыг нь сайтар ухамсарлуулж ойлгуулдаг уу. ■

Эдийн засаг, бизнесийн мэдээлэл
24 цагаар таны сонорт..

Бизнес сонирхогчдыг “хөл дээр нь босгодог” ADIA

Энэхүү загвараар мэдээлэл авсан хэрэглэгч таны хэтэвч рүү мөнгөө “юүлж” эхэлнэ

Д.Хулан, ЗГМ сонин

Бизнес эрхлэхээр шийдэн, үйл ажиллагаагаа хүнд хэрхэн хүргэхээр төлөвлөж буй бүхэнд зуу гаруй жилийн түүхтэй ADIA маркетингийн загварыг танилцуулъя. Оёсон хувцсаа борлуулах, үсчин гоо сайхны салон нээх, онлайн худалдаа эрхлэх зэргээр бичил бизнес эхлүүлэхээр зэхэж байгаа бол анхаарлаа хандуулаарай.

ШИНЖЛЭХ УХААНЫ ЗАГВАРААР ТӨЛӨВЛӨ

АНУ-ын бизнесмэн Эльмо Луисын 1898 онд боловсруулсан уг загвар одоо ч үнэ цэнээ алдаагүй. Тэрбээр олон компанийн маркетингийн албаны дарга хийж байсан төдийгүй зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байв. Энэ бол зар сурталчилгаа, борлуулалтын үйл ажиллагааг шинжлэх ухааны аргаар явуулах үндэс юм. AIDA буюу бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах явцад хувь хүний явуулдаг танин мэдэхүйн attention (анхаарал татах), interest (сонирхол хадгалах), desire (хүсэл төрүүлэх), action (үйлдэл хийлгэх) дөрвөн үе шатыг зөв мэдэрч, зохион байгуулвал амжилтад хүрч болохыг тодорхойлсон юм. Энэхүү дамжлагаар орсон хэрэглэгч таны хэтэвч рүү мөнгөө “юүлдэг” тул зайлшгүй анхаарч, хэрэглэгчээ мэдэрч ажиллах нь амжилтын үндэс болно.

АНХААРАЛ ТАТАХ

Юун түрүүн бүтээгдэхүүн үйлчилгээ рүүгээ анхаарлыг тат. Юуных нь мэдэгдэхгүй далд утгатай сурталчилгаа хэсэг явуулж, олон нийт юуны тухай болохыг мэдэхийг хүсэх хүлээлт үүсгэдэг тохиолдол олон гардаг шүү дээ. Харин бизнесээ эхлүүлж буй хувь хүн энгийн амьдралын сэтгэл татам жишээг өгүүлж өхөөрдөм, эсвэл гайхшруулсан зураг ашигласан пост социалдаа оруулж болно.

1

СОНИРХОЛ ХАДГАЛАХ

Нууцлаг, эсвэл хайр татам, сэтгэлд хоногшсон постер, бичлэгүүдийн тайллыг одоо гаргах цаг. Энэ нь хүртээмжээсээ хамаарч 7-14 хоногийн дараа байж болно. Гэхдээ зорилтот хэрэглэгчдэд хангалттай хүрч чадаагүй бол эхний алхамаа өөр хэлбэрээр давтахыг санал болгоё.

2

ХҮСЭЛ ТӨРҮҮЛЭХ

Таны бүтээгдэхүүн үйлчилгээг мэддэг боллоо, одоо худалдан авах хүсэл төрүүлэх чухал цаг ирлээ. Үүний тулд бүтээгдэхүүн үйлчилгээг төрөл төрлөөр нь ангилж, хялбар, ойлгомжтой байдлаар богино хугацаанд мэдээлэл авч болохуйц бэлтгэсэн “меню”-гээ танилцуулж болно. Мөн хөнгөлөлт урамшуулал, дахин үйлчлүүлэх эрх, дараагийн худалдан авалтын үнэгүй хүргэлт гэх мэт урамшууллаар “чимэглэж” өгөх хэрэгтэй. Үнэ, хаяг, байршил, цагийн хуваарь, хүргэлтийн мэдээллээ мартуузай.

3

ҮЙЛДЭЛ ХИЙЛГЭХ

Сонирхол татсан зүйлээ мэддэг болсон, авах хүсэлд автаж буй хэрэглэгчдийг одоо үйлдэл хийлгэх л үлдлээ. Дуудлага бүрт хариулан, хурдан шуурхай хүргэж, аелдэг угтан, сэтгэл ханамжтай үйлчлүүлэх нөхцлийг бүрдүүлэх зэргээр маш их хүчин чармайлтаар олж авсан хэрэглэгчээ алдахгүйн төлөө ажиллаарай.

4

ХАДГАЛАЛТ

Орчин үед энэхүү загварт нэмэлт оруулж, үйлчлүүлэгч, хэрэглэгчдээ алдахгүй, хадгалахын чухлыг сануулсан билээ. Шинэ бүтээгдэхүүн, урамшуулал, хямдралын талаар тэдэнд зориулж хамгийн түрүүнд мэдээллээ хүргэж байгаага олон дурдаад давтамжтай мэдээллээр хангаж байгаарай. Танай салбар нүүх болсон, цагийн хуваарь өөрчлөгдсөн зэргийг хамгийн түрүүнд худалдан авагч, үйлчлүүлэгчид чинь мэдсэн байх шаардлагатай.



Гоо сайхны салбарт манлайлагч Francesco group ADIA загварыг ингэж ашиглажээ

Энэхүү маркетингийн загвараар 50 жилийн өмнө үйл ажиллагаагаа эхлүүлсэн, өнгөрсөн жилийн Night awards 2019-ийн эзэн Francesco group-ийн шинэ салбар салоноо ажиллуулахдаа ADIA загварыг хэрхэн ашигласныг сонирхуулъя.

АНХААРАЛ ТАТАХДАА

Стилистүүд, мэргэжлийн гоо сайханч, үсчнээ сурталчлахаас дөрвөн сарын өмнө шинэ кампанит ажлынхаа зорилтот хэрэглэгчдийн бүлгүүдэд зориулсан сурталчилгаа явуулсан.

СОНИРХОЛ ХАДГАЛАХЫН ТУЛД

Үнэгүй зөвлөгөө өгөх, үсээ тайруулах, урамшуулалт кампанит ажил гүйцэтгэв. Эмэгтэйчүүдийн дунд явуулсан “нэг газраа үнэнчээр үйлчлүүлэх дуртай” гэсэн судалгааны дүнг танилцуулжээ.

ХҮСЭЛ ТӨРҮҮЛЭХДЭЭ

Шинэ салоны нээлтийн дэргэд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, социал медиагаар сурталчилгаагаа өргөн хүрээтэй зохион байгуулав. Энэ нь “орон нутгийн чанартай” гэхээсээ илүү “зөвхөн танд хүрэхийн тулд” гэсэн санааг агуулж байлаа.

ҮЙЛДЭЛ ХИЙЛГЭХИЙН ТУЛД

Тодорхой цагт өндөр урамшуулал зарлаж, эхний үйлчлүүлэгчдэдээ хөнгөлөлтийн карт олгохоо мэдээлжээ.

✍ О.Даваасүрэн, ЗГМ сонин

“Ардын аниа GiGi” нэрээр цахим хэрэглэгчдэд танигдсан Г.Ган-Эрдэнэтэй ярилцлаа. Lindenwood их сургуулийг Бизнесийн удирдлага мэргэжлээр төгссөн тэрбээр хэрхэн гадаадад суралцах, яаж АНУ-д ажиллах зэрэг влог хийж, хүмүүст хүргэдэг. Түүнчлэн эерэг энерги түгээх зорилготой хөгжилтэй бичлэг хийдэг түүнийг цахим сүлжээнд цөөнгүй хүн дагадаг. Монгол хүнтэй гэр бүл болж, эх орондоо амьдрах хүсэлтэй түүнтэй хийсэн ярилцлагаа хүргэж байна.

-Таныг социал инфлюенсер гэдгээр хүмүүс эчнээ мэддэг болсон. Бичлэгүүдийг чинь алгасалгүй үздэг хүмүүс ч цөөнгүй. Анх яагаад влог хийх болсноос яриагаа эхлэх үү?

-Өөрт тохиолдсон адал явдлыг бичлэг болгон хадгалах нь дурсгалтай учир оюутан байхаасаа л сонирхолтой бичлэг хийдэг байсан. Гэхдээ түүнийгээ зөвхөн компьютертээ хадгалдаг байлаа. Харин хүмүүсийн влогийг үзээд “бичлэгээ олон хүнд хүргэж болох юм” гэж бодогдох болсон. Ийнхүү шинэ жилийн үдшийг гэр бүлээрээ тэмдэглэж буйгаа бичлэг болгож, анх цахим хуудсандаа байршуулж байлаа. Надад маш сонирхолтой санагдсан. Гэхдээ өөрийнхөө юу хийж, хэрхэн амьдарч байгааг нийтлэх нь ач холбогдолгүй юм билээ. Тиймээс 10-20 минутын хугацаанд хүмүүст хэрэгтэй, сонирхолтой мэдээлэл хүргэхийг хичээдэг болсон. Гэхдээ миний бичлэгүүд нэг хэв маягт баригддаггүй. Учир нь хүмүүс наснаасаа хамаарч өөр, өөр төрлийн мэдээлэл

Г.Ган-Эрдэнэ: Монголд сурдаг оюутнуудад атаархдаг байсан

Залуучууд ирээдүйдээ санаа тавьж, судалж, суралцдаг болсон нь анзаарагдсан. Хувь тавиланд итгээд, гараа хумхиад суудаг хүн цөөхөн болжээ.

хүлээж авдаг нь анзаарагдсан. Тухайлбал, хөгжилтэй, инээдмийн бичлэгийг арван жилийн хүүхдүүд их үздэг. Харин 20-30 насныхан хэрхэн төлөвлөгөө гаргаж, үр дүнтэй ажиллах, яаж өөдрөг байх зэрэг мэдээллийн шинж чанартай бичлэг хүлээж авах сонирхолтой байдаг. Тиймээс төрөл бүрийн влог хийж, аль болох нас, насны хүнд хүргэхийг зорьдог.

-Бичлэг хийж хүмүүст танигдана гэдэг амаргүй байх. Цаг хугацаа ч их шаарддаг болов уу. Хэзээнээс хүмүүст таныг “Ардын аниа GiGi”-р таньдаг болсон бэ. Мөн анх хамгийн их хүнд хүрсэн бичлэг юу байсан?

-Үнэнийг хэлэхэд, анх бичлэгийг маань олон хүн үздэггүй байсан. Миний

хүрээллийн, таньдаг хүмүүс л хардаг байсан байх. Гэхдээ надад үнэхээр сонирхолтой байсан учир хүмүүс үзэх эсэх нь сонин байгаагүй. Тиймээс үзэхгүй байна гээд орхиогүй юм. Шөнийн турш бичлэгээ эвлүүлээд суух үе ч цөөнгүй байлаа. Мөн үүнийг хийснээр би их өөрчлөгдсөн л дөө. Өөрийгөө илэрхийлэх чадвартай болсон. Сул үг хэрэглэж ярьдаг байснаа ч больсон. Энэ мэт надад эерэг өөрчлөлтүүд бий болсон болохоор урам зоригтой влогоо хийж, нийтэлдэг болсон. Анх камер бариад ярихаар өөрөө өөртэйгөө яриад байгаа юм шиг эвгүй сэтгэгдэл төрдөг юм билээ. Өөрийнхөө бичлэгийн эвлүүлэх бүр ч инээдтэй. Хамгийн анх олон хүнд хүрсэн бичлэг бол миний хэрхэн

турсан тухай влог байсан юм. Төсөөлснөөс их хандалт авсан шүү.

ХҮМҮҮС НАМАЙГ МОНГОЛ ЗАЛУУТАЙ ҮЕРХЭЖ БАЙГААГ ГАЙХАЖ ХҮЛЭЭЖ АВСАН НЬ СОНИН САНАГДСАН. БИ МОНГОЛ ХҮНД Л ДУРТАЙ ИРЭЭДҮЙН НӨХРӨӨ ЭХ ОРНООСОО СОНГОНО ГЭЖ БОДДОГ БАЙЛАА.

-Цахим сүлжээнд бичлэг нийтэлж, хандалтын тоогоор цалинждаг хүмүүс цөөнгүй болсон. Та Youtube-ээс цалин авч байв уу?

-Бичлэг маань олон хүнд хүрч эхэлснээс хойш надад бизнесийн санал маш их ирдэг болсон. Гэхдээ би тэдгээр саналыг хүлээж авдаггүй. Харин Youtube-ээс тодорхой хэмжээний цалин авдаг. Хөгжүүлээд явбал их мөнгө олох боломжтой юм билээ. Гэхдээ надад түүнд зарцуулах зав гардаггүй.

-АНУ-ын Сиэтл хотод дүүтэйгээ хамт амьдардаг гэсэн. Аав, ээж нь Монголд байдаг уу?

-Би Эрдэнэт хотынх. Нэг ах, нэг дүүтэй. Ах, дүү хоёр маань бас АНУ-д амьдардаг, харин аав, ээж хоёр минь Монголдоо байгаа. Би нэг зүйл хэлмээр

санагддаг юм. Зарим хүн баян айлын хүүхдүүд л гадаадад сурч, ажилладаг гэж боддог. Бид гурвуулаа энд байдаг болохоор аав, ээж нь баян учраас хөрөнгөөр нь ингэж яваа гэж боддог хүн их байдаг байх. Заримдаа бичлэг, зурагны доор ийм сэтгэгдэл их харагддаг. Үнэндээ, манайх энгийн л дундаж амьдралтай айл. Хүүхдүүдээ сайхан амьдраасай, сайн хүн болоосой гэсэндээ ээж, аав минь цаг наргүй хөдөлмөрлөж, өөрийнхөө эдэлж, хэрэглэх бүхнийг бидэнд зориулдаг. Мөн бид ч эрвийх, дэрвийхээрээ хичээдэг. Байрны түрээс, хэрэглээний зардлаа өөрсдөө олж, аль болох “ачаа” болохгүйг эрмэлздэг.

-Таныг Ган-Эрдэнэ нэрээр чинь хүмүүс сайн мэддэггүй байх. Учир нь “Ардын аниа GiGi” нэрээрээ танигдсан. Яагаад ингэж нэрлэх болсон бэ?

-Анх Youtube-т хэрхэн англи хэл хэрхэн сурах, яаж турах зэрэг мэдээлэл өгөх зорилгоор бичлэг хийж эхэлсэн чинь “аниа надад туслаач, эгчээ надад зөвлөөч” гэсэн зурвас маш их ирсэн. Ихэвчлэн ЕБС-ийн хүүхдүүд холбогдож байсан болохоор тэгсэн байх. Үүнээс үүдээд “Ардын аниа” гээд нэрлэчихсэн юм. Gi Gi гэдэг нь миний овог, нэрийн товчилсон хувилбар л даа. Заримдаа надаас ах, эгч хүн “Ардын аниа, ардын элч ээ” гэж дуудахаар эвгүй санагддаг л юм. /инээв/

-ЕБС-ийн хүүхдүүд холбогдож, зөвлөгөө их авдаг гэлээ. Ер нь сүүлийн үед залуучууд хэл сурч, гадаадад сурах сонирхолтой болсон. Энэ талаар ямар бодолтой байдаг вэ?



HAPPY VALENTINE'S DAY

73,915 views • Feb 14, 2020



SUBSCRIBE

☉ Тэрбээр Youtube хуудсандаа 105 мянга, Facebook-тээ 200 орчим мянган дагагчтай.

-Тийм шүү. Залуучууд ирээдүйдээ санаа тавьж, судалж, суралцдаг болсон нь анзаарагдсан. Хувь тавиланд итгээд, гараа хумхиад суудаг хүн цөөхөн болжээ. Над руу маш олонхүүхэд холбогдож, зөвлөгөө авдаг. Би их сургуульдаа 40 хувийн тэтгэлэгтэй суралцсан. Магадгүй сайн судалсан бол илүү боломж байсан байх гэж боддог. Тухайн үед надад зөвлөгөө өгөх хүн байгаагүй. Тиймээс надаас тусламж хүссэн хүмүүст аль болох мэдээлэл өгөхийг хичээдэг. Гэхдээ манайхан жаахан залуу, тууштай биш юм шиг санагддаг. Хэрэв зорьсон л бол ямар ч саад тулгарсан бууж өгөхгүй хичээдэг байх хэрэгтэй.



-Залуучууд гадаадад суралцаж, дэлхийн хэмжээний боловсрол эзэмших хүсэлтэй болсон нь илт анзаарагдлаа. Бакалаврын боловсролыг Монголд эзэмших, АНУ-д суралцах харилцан адилгүй байх?

-Би ЕБС-иа Эрдэнэт хотын "Мон-Турк" сургуульд төгссөн. Тэнд сурч, турк хэл сурсан болохоор цаашдаа Турк явна гэж боддог байлаа. Гэхдээ гэр бүлийнхнийхээ зөвлөснөөр энд ирсэн. Аав, ээжийн бяцхан охин хайртай бүхнээсээ хол, хүний нутагт бие дааж амьдарна гэдэг амаргүй юм билээ. Заримдаа Монголд сурдаг оюутнуудад атаархдаг л байлаа. Учир нь тэд ээж, аавтайгаа, эх орондоо сурч байгаа болохоор санаа зовох зүйл багатай, ямар ч зүйл тохиолдсон өмөөрч, өмгөөлөх өмөг түшиг нь хажууд нь байдаг юм шиг санагддаг. Харин хилийн чанадад суралцаж байгаа хүүхдүүдийн хувьд бүх зүйл эсрэгээрээ. Бүх л хариуцлага, ачаа өөрийн нуруун дээр ирдэг.



Ямар ч асуудал тулгарч, юу ч тохиолдож байсан бүхнийг өөрөө зохицуулдаг. Ийм нөхцөлд амьдарч байх үед өвдөх хамгийн хэцүү юм билээ. Хүн сул дорой үедээ хайртай бүхнээ хамгийн их санадаг. Заримдаа Монголд оюутан байж үзмээр санагддаг л юм. Гэхдээ надад тийм боломж олдохгүй байх. Ирэх наймдугаар сараас эндээ мэргэжил дээшлүүлж сурахаар төлөвлөсөн. Гэхдээ АНУ-д бакалаврт сурсан нь сайн хэрэг гэж боддог. Учир нь амьдралыг харах өнцөг маш их өөрчлөгдсөн. Энд хүмүүс ямар нэг зүйлд баригдахгүй, задгай сэтгэдэг. Мөн асуудлыг зоригтой шийдэж, бие биеэ дэмжиж, хамтарч ажиллах чадвартай байдаг.

-Саяхан найз залуутайгаа авахуулсан зургаа цахим хуудсандаа нийтэлсэн "GiGi найз залуутай болжээ, монгол залуутай үерхэж байна" зэрэг мэдээлэл цацагдсан л даа. Найз залуугийнхаа тухай ярьж болох уу?

-Хүмүүс намайг монгол залуутай үерхэж байгааг гайхаж хүлээж авсан нь сонин санагдсан. Би монгол хүнд л дуртай. Тиймээс ирээдүйн нөхрөө эх орноосоо сонгоно гэж боддог байлаа. Найз залуугаа анх Сиэтл хотод зохион байгуулагдсан наадмын үеэр харсан юм. Тухайн үед сайн

анзаараагүй. Дараа нь энд гар бөмбөгийн тэмцээний үеэр таарахад нүдэнд дулаахан залуу шиг санагдсан. Гэхдээ над руу муухай хараад байсан болохоор "надад дургүй бололтой" гэж бодож байлаа. Гэтэл үгүй байсан юм билээ. /инээв/ Бид хоёр үерхээд хоёр сар л болж байна.

-Монголчууддаа дуртай гэлээ. Ирээдүйд эх орондоо ирж ажиллах хүсэл байна уу?

-2-3 жилдээ энд амьдрах байх. Учир нь мэргэжил дээшлүүлж, сурахаар төлөвлөж байгаа. Харин цаашдаа Монголд амьдрахыг хүсдэг. Миний анзаарснаар Монголын компаниуд гадаадад боловсрол эзэмшсэн залууст маш их боломж олгодог. Энд их сургуульд сураад төгссөн олон залуус эх орондоо очиж ажиллаад сайхан амьдарч байна. Гэхдээ ажлын нөхцөл ямар байдгийг сайн мэдэхгүй юм. Би сургуулиа төгсөөд Amazon компанид ажилласан. Тэнд ажилчдаадаа маш олон боломж олгодог. Жишээ

нь, даатгал сайн хийдэг. Мөн заавал ажлын цагаар оффисын ширээний ард сууж ажиллах шаардлагагүй. Хүссэн газраасаа ажлаа хийх боломжоор хангадаг. Өөрөөр хэлбэл, ажлын бүтээмжид ач холбогдол өгдөг нь их таалагдсан. Монголын компаниуд ч гэсэн ийм системээр ажилаасай гэж бодогддог. ■



KING TOWER
LUXURY APARTMENT & PENTHOUSE

ЗАХИАЛАГЧ БҮРТ

Ariunaa Suri

**БРЭНДИЙН
ХОС ДЭЭЛ ХИЙЛГЭХ
БЭЛГИЙН КАРТ
БЭЛЭГЛЭЖ БАЙНА**

Утас: 88887063, 99923536 | www.kingtower.mn



SKY GARDEN

Дэлхийн барилга, архитектурын салбарт вертикал буюу босоо чиглэлд хөгжүүлсэн ногоон байгууламжийг Sky Garden хэмээн нэрийддэг бөгөөд энэхүү шийдлийг төлөвлөлтөнд тусгаснаар өндөр түвшний барилгад байгалийн мэдрэмжийг бодитоор хүртэх боломжийг бүрдүүлсэн.

VERTICAL GARDEN • BOSCO



True Luxury ЗӨВ ТАНСАГЛАЛ



Сэтгэлд нийцэх "Байршил"

Ногоон бүсийн үнэ цэнэтэй байршил, 180-360 градус харах өнцөгтэй



Ирээдүйгээ хайрласан "Хүүхэд төвтэй төлөвлөлт"

Хүүхдийн эрүүл аюулгүй хөгжих орчин



Winter Garden

Дөрвөн улирлын цэцэрлэг 4-н улирлын ногоон байгууламж



Аюулгүй байдлыг бүрэн хангасан "Дугуйн гүүрэн гарц"

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнтэй холбогдсон аюулгүй гарц



Рашаан түгээх системтэй

Дөрвөн улирлын турш гэртээ рашаанд орох боломж



Чанарын баталгааг амлах "Материалын сонголт"

Дэлхийн шилдэг чанартай материалаар брэнд орчинг цогцлоосон



Бүхнийг цогцлоосон "Sky Park Plaza"


Хүний бүх хэрэгцээг нэг дор цогцлоосон нэгдсэн үйлчилгээний төв



Газар доогуурх зам бүхий "Галерей"

Хотхоны бүх барилга болон үйлчилгээний төв газар доогуураа туннелээр холбогдсон

Sky Garden Residence...
Yet within, peace and calm prevails.



SKY | GARDEN | RESIDENCE



Борлуулалтын оффис | Sales Office
+ 976 771 55555

Борлуулалтын менежер | Sales manager
+ 976 8888 0835, 8888 0836, 8888 0837

skygarden.mn
info@skygarden.mn



✍ О.Даваасүрэн, ЗГМ сонин

Уран нугараач гоо бүсгүй А.Бөртэ-
Үжин дэлхийн гоо үзэсгэлэнт,
авьяаслаг бүсгүйчүүд эх орноо
төлөөлөн өрсөлддөг Miss Super-
talent of the world буюу “Дэлхийн
авьяаслаг миссийн тэмцээн”-д
тэргүүн байр эзэлж байсан
билээ. Түүнийг энэ удаагийн “Гоо
сайхан” буланд аонцолж байна.
Олон улсын үзэгчдэд уян хатан
бие, уран тансаг үзүүлбэрээрээ
сайшаагдсан тэрбээр зөвхөн
нугарах төдийгүй бүжгийн
багшаар ажилладаг авьяаслаг
нэгэн.

- » **Биеийн жин:** 57кг
- » **Биеийн өндөр:** 175 см
- » **Биеийн харьцаа:** 90:59:89 см
- » **Биеийн таалагддаг хэсэг:**
Нүд, цээж
- » **Төрсөн он, сар, өдөр:** (Нууц)
- » **Орд:** Ихэр
- » **Үсний өнгө:** Бор
- » **Нүдний өнгө:** Хүрэн бор
- » **Төгссөн сургууль:** СУИС
- » **Ажил:** Уран нугараач, бүжгийн
багш
- » **Мэргэжил:** Уран нугараач
- » **Идэх дуртай хоол:** Төрөл
бүрийн хоолонд дуртай
- » **Дуртай өнгө:** Цагаан
- » **Дуртай брэнд:** Versace
- » **Дуртай сүрчиг:** Dior Addict,
Calvin Klein Beauty
- » **Хобби:** Ном унших
- » **Зорилго:** Маш олон зорилго
бий
- » **Баримталдаг зарчим:**
Тэвчээртэй байх, аливаад
талархах, асуудлыг эерэгээр
харах
- » **Үзэх дуртай кино:** Бодит
амьдралаас сэдэвлэсэн,
нууцлаг
- » **Хэлэх дуртай үг:** Баярлалаа
- » **Өглөөг хэрхэн эхлүүлдэг вэ:**
Тухайн өдрийн төлөвлөгөөгөө
гаргаад, ус эсвэл ногооны
шүүс уудаг
- » **Instagram:** burteujinm

УРАН
НУГАРААЧ
ГОО БҮСГҮЙ


А.БӨРТЭ-ҮЖИН



PEN BOUTIQUE

2nd floor, Central tower, 2
Sukhbaatar square, khoroo 8,
Sukhbaatar district

 penboutiquemongolia

 penboutique.mn

 7000-9880

Хиймэл цагдаа Шинэ Зеландад үүрэг гүйцэтгэж эхэллээ

Шинэ Зеландын нийслэл Веллингтон хотын цагдаагийн газрын төв байранд хүрэлцэн ирсэн үйлчлүүлэгчдийг өнөөдрөөс эхлэн Элла нэртэй шинэ ажилтан угтаж авна. Элла нь Шинэ Зеландын цагдаагийн албанд зориулсан орон нутгийн Intel AI болон Soul Machines мэдээллийн технологийн компанийн хамтран бүтээсэн хиймэл оюун юм. Элла бие мах бодгүй, гудамжаар эргүүл хийж чадахгүй ч үйлчлүүлэгч нартай эелдэг харьцаж, хүлээцтэй хандах чадвартай. Цагдаагийн газрын төв байраар зочилж буй зочин, үйлчлүүлэгч, дотоод ажилтнуудтай байнга харьцах замаар Элла гурван сарын турш бодит орчин нөхцөлд дасган сургаж, зүгшрүүлэх аж. Элла нь бусдад зөвлөх үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ харьцаж буй хүмүүсийн биеэ авч явах байдал, зан

авиртай холбоотой статистик цуглуулж, цуглуулсан өгөгдлөөрөө өөрийгөө сайжруулж хөгжүүлэх юм.

Цагдаагийн хиймэл оюун – Элла сэтгэлийн хөдөлгөөн илэрхийлдэг дохио зангаа зэрэг бие мах бодийн хэл ашиглан үйлчлүүлэгчтэйгээ яриа өрнүүлэх чадвартай. Мөн цагдаагийн үндсэн ажил үүрэгтэй холбоотой суурь заавар зөвлөмж өгөхийн зэрэгцээ зөвхөн мэдээлэл өгөх үйлчлүүлэгчийн яриаг сонсож санах, онцгой нөхцөлд ажиллах шуурхай албатай холбож өгнө.

Хиймэл оюун гэмт хэрэг болон хувь хүний мэдээлэл зэрэг “хаалттай хүрээний” мэдлэг эзэмшихгүй, зөвхөн нарийн тодорхой зааж өгсөн явцуу хүрээнд үйлчилнэ гэдгийг Шинэ Зеландын цагдаагийн алба тайлбарлаж байна. ■

Nike Space Hippie хамгийн “ногоон” гутал болно

Спортын гутал үйлдвэрлэхэд маш олон төрлийн түүхий эд, материал ашигладаг. Nike компани Space Hippie буюу “Сансрын хиппи” гэдэг шинэ загварын гутал хийхдээ “материалын төрөл цөөн байх тусам байгальд ээлтэй” гэсэн зарчим баримталжээ. Уг зарчмын үр дүнд шинэ гутал үндсэндээ дахивраар бүтсэн бүтээгдэхүүн болов.

Adidas x Parley спорт гутлыг хуванцрын хаягдлаар бүтээсэн бол Nike Space Hippie-гийн дээд хэсгийг хуванцар лонх, хаягдал футболк, нэхдэс материалын өөдсийг

дахин боловсруулж гаргасан бөс даавуугаар хийжээ. Улавчийг нь тус компанийн гүйлтийн гутлын үндсэн түүхий эд Nike ZoomX-ийн хаягдал материалаар, улыг Crater Foam хөөсөнцрийн үлдэгдлээр бүтээсэн байна. **Зөвхөн үйлдвэрлэлийн хаягдал, өөдөс материалаар бүтсэн Space Hippie нь Nike-ийн түүхэнд нүүрстөрөгчийн давхар ислийн ялгарал тун бага бүтээгдэхүүн болж байна.**

Дотроо дөрвөн өөр төрөл загвар бүхий Space Hippie гутлыг энэ хавраас худалдаанд гаргана. ■



Дэлхийн агаар мандлыг “глобал” сенсор болгох Пентагоны төлөвлөгөө

О.Мишээл, ЗГМ сонин

Дэлхийн агаар мандал болох атмосфер хэмээх олон олон үет давхаргуудаас хүн төрөлхтөн далайн түвшнээс дээш 17-20 километрийн өндөрт орших тропосферын харьцангуй нимгэн давхаргыг илүү судалжээ. Хүн төрөлхтөн байнга ажиглан судлах ажил үүрэгтээ тропосфероос бусад давхаргыг өдий хүртэл оруулаагүй явж ирсэн “дутагдал”-ыг АНУ-ын цэргийнхэн залруулахаар шийдлээ.

Атмосферын нийт давхаргыг ажиглаж хянах замаар дэлхий дээр локал өрнөж буй үйл явдалтай холбоотой өгөгдөл цуглуулж болно.

Далайн түвшнээс дээш 10 мянган километр хүртэлх өндрийг хамран орших экзосферыг оролцуулаад атмосферын нийт давхаргад үүсэж буй өөрчлөлтийн механизмыг судлан тайлах “Атмосфер-сенсор” буюу AtmoSense хөтөлбөрийг АНУ-ын Батлан Хамгаалах Яамны цэргийн технологи хариуцсан DARPA (Defense Advanced

Research Projects Agency) агентлаг хэрэгжүүлж эхэллээ. Дэлхийн гадаргаас ионосфер

хүртэлх орчинд эрчим хүч тархах зарчмыг судалж, атмосферийг сенсор-мэдрэх төхөөрөмж болгон ашиглах боломжийг нээн илрүүлэхэд уг судалгаа чиглэх юм.

Цунами, хар салхи, газар хөдлөлт, галт уул оргилох, мөндөр буух, солир харвах, дэлхий орчимд сүүлт од өнгөрөх зэрэг байгалийн хүчин зүйлс, пуужин

харвах, бөмбөг дэлбэлэх зэрэг хүний үйл ажиллагаатай холбоотой үзэгдлийг дэлхийд хянах чадвартай төхөөрөмжийг хүн төрөлхтөн одоогоор бүтээж чадаагүй байна. Дээр дурдсан үзэгдэл, хүний үйл ажиллагаа манай гарагийн агаар мандалд ямар ул мөр үлдээдэг, үлдээсэн ул мөрийг нь бүртгэх замаар дэлхий дээр болж буй үзэгдлийн

байршлыг тодорхойлох нь DARPA-гийн судлаачдын зорилго юм.


Дэлхийн гадаргаас ионосфер хүртэлх орчинд эрчим хүч тархах зарчмыг судалж, атмосферийг сенсор-мэдрэх төхөөрөмж болгон ашиглах боломжийг нээн илрүүлнэ.

Зарчмын хувьд дэлхийн гадарга дээр өрнөж буй бүх үйл явдал атмосферын давхаргад тодорхой хэмжээний нөлөө үзүүлж агаарын даралт, нягтрал, температурт “гурван хэмжээст” мөр үлдээдэг.

Одоогоор эрдэмтэд тропосфероос дээших атмосферын давхаргыг бараг

судлаагүйтэй адил. Иймд AtmoSense хөтөлбөрийн хүрээнд хоёр шаттай судалгаа өрнүүлэх юм. Эхний 27 сард дэлхий дээр өрнөж буй үйл явдал атмосферт ямар ул мөр үлдээж буйг судлан тодорхойлох ерөнхий концепц боловсруулах аж. Дараагийн шатанд эрдэмтэд батлагдсан онолын хүрээнд туршилт явуулж эхэлнэ. ■

Diamond Princess-т байгаа хүмүүст 2000 ширхэг iPhone тараажээ



Коронавирус тархсаны улмаас Японы Йокохамагийн боомтод хориотой зогсож буй Diamond Princess круиз онгоцон доторх зорчигч болон хөлгийн багийнханд шаардлагатай шуурхай холбоо үүсгэх үүднээс iPhone ухаалаг утас тараасныг Macotakara сайт мэдээлэв.

Круиз онгоцны зорчигчийн тасалгаа, багийнхны өрөөний тоогоор тооцож, Японы үүрэн холбооны Softbank компанийн холболттой 2000 ширхэг iPhone ухаалаг утсыг хуваарилжээ.

Шаардлагатай үед яаралтай холбоо барихад тус болох үүднээс тус утсанд нь эмчтэй шууд холбогдох мобайл аппликэйшн суулгажээ.

“Эм тариа зэрэг шаардлагатай зүйлсийн талаар чатаар лавлах, хүсэлт гаргах, эмчээс зөвлөгөө авах гэвэл Японы Эрүүлийг Хамгаалах, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамны тусгай программ ашиглана уу” гэсэн тайлбарыг уг программын ашиглалтын зааварт бичжээ.

Уг хөлөг дээр байгаа иргэдээ АНУ ням гарагт шилжүүлж авахаар болсныг Токио дахь Элчин сайдын яамнаас мэдэгдсэн байна. ■

ZGM DAILY

⊕ Atar Urguu ends 2019 with MNT 10.4 billion sales revenue

Atar Urguu JSC, the first bread and baked food manufacturing company established in Mongolia, reported revenue of MNT 10.4 billion in 2019.

⊕ Enhanced coal dopants reserves equal 50 tons

Tavan Tolgoi Tulsh LLC (TTT) reported that there will be no shortage of enhanced coal. Specifically, officials received 50 tons of dopants from China and currently have 10 days of reserves.

World Bank: Mongolia needs to continue strengthening fiscal policy

Novel coronavirus outbreak may adversely affect the Mongolian economy



Image by Batsaikhan.S

✍️ Aminaa.U, ZGM Daily

The World Bank announced Mongolia's Economic Review Report on Friday. The country's economic growth has moderated slightly in recent years, but the medium-term outlook remains positive, the report said.

Considering the current situation of Mongolia's economy, which is highly dependent on China, the impact of the new coronavirus may adversely affect the Mongolian economy, highlighted Andrei Mikhnov, World Bank Country Representative in Mongolia. He said, "The economic outlook is positive the medium-term, however,

continuing to strengthen fiscal policy and maximizing foreign exchange reserves by keeping the FX interventions at a decent level remains the two most important policy goals for policymakers. Government's economic reform in 2020 will play a significant role in market outlook and foreign direct investment of Mongolia."

Previously in April, it anticipated Mongolia's economy to grow 6.9 percent in 2019 and 6.3 percent in 2020. The report cautions of the risks, namely the political uncertainty, commodity price fluctuations, cross-border bottlenecks, implementation delay mega projects, and slower

implementation of banking sector reforms.

In 2020-2021, the economy is expected to grow by an average of 5.6 percent, due to sustained growth in personal consumption and investment in the mining and industrial sectors. The Government of Mongolia also said that it would continue a unified fiscal policy aimed at continuing to reduce government debt in the medium term by increasing budget revenues and efficiently optimizing the spending.

Highlights of the report include the banking sector's credit process or dynamics, especially in light of recent developments, actions

taken by the government and policymakers, and some policy recommendations.

World Bank Senior Economist for Mongolia, Jean-Pascal N. Nganou said, "Strengthening the stability of the financial sector, in particular, lending policies and the stability of the banking sector is important in improving macroeconomic stability, increasing employment, and thereby reducing poverty. Monetary policymakers, who have tightened their monetary policy since the end of 2018, have been maintaining credit growth. In the future, it is crucial to prevent the risks that may arise through proper macro-policies." ■

ZGM: HIGHLIGHTS

▪ **POLITICS**

President of Mongolia, Battulga Khaltmaa presents the letter of credence to newly appointed Ambassador Extraordinary and Plenipotentiary of Mongolia to the Republic of Poland and the Kingdom of Sweden Dorj Barkhas and Janabazar Tuvdendorj.

▪ **ECONOMY**

Remicon JSC, MSE tier-II listed which produces concrete batching, announces the annual report of 2019. The company's sales revenue rose to MNT 13.5 billion. This is a 47 percent increase from a year ago.

According to the MSE, Hermes JSC to allocate dividends total of MNT 322 million or MNT 4.1 per share from annual net income to shareholders. The list of shareholders will be released on February 28, 2020.

Top 20 index rises 0.11 percent, to 18,983.3 points. MSE A index increases 0.16 percent, to 9,338.49 points. MSE B index decreases 1.18 percent, to 7,702.55 points. Market cap stands at MNT 2.72 trillion.

▪ **SOCIETY**

In accordance with coronavirus case has been confirmed 80.7 miles from Gashuunsukhait port, it starts to provide truck drivers who transport the coal to the direction of Tavantolgoi-Tsagaankhad with health care and it is cooperating with transportation companies to accelerate the return of those drivers amidst the quarantine.

STOCK MARKET

Atar Urguu ends 2019 with MNT 10.4 billion sales revenue



Image by Batsaikhan.S

Companies listed on the Mongolian Stock Exchange (MSE) had started presenting their 2019 financial reports. **Atar Urguu JSC, the first bread and baked food manufacturing company established in Mongolia, reported revenue of MNT 10.4 billion in 2019. This is a 26 percent decrease from the previous year.**

During the reporting period, the net profit of the company increased by 17 percent to MNT 280 million compared to the same period of the previous year. This was driven by lower prices and reduction of costs, the company said.

Atar Urguu supplies roughly 1,600 bakeries to more than 30 percent of the consumers in the capital city.

In the meantime, Talkh Chikher reported revenue of MNT 54.8 billion for the fiscal year 2019. This is an increase of 17.7 percent over the previous year. In the same period, the net profit of the company increased by 24.2 percent year-on-year, reaching MNT 2.4 billion. The increase in net profit was mainly driven by the increase in material prices by about 20 percent and the modernization of equipment, which increased gas production capacity. The company also introduced the

brand named Special for a healthy lifestyle, which was in demand by the market last year. Talkh Chikher satisfies about 27 percent of domestic bakery products and 60-65 percent of bread products.

According to the Customs General Administration (CGA), bread and pastry products have not been exported as of December 2019. During the same period, the import of these kinds of products increased by 121 percent to USD 590,000. About 50 percent of them are being imported from Russia along with Ukraine, China, Korea, Vietnam, and Turkey. ■


SOCIETY

Enhanced coal dopants reserves equal 50 tons

Tavan Tolgoi Tulsh LLC (TTT) reported that there will be no shortage of enhanced coal. Specifically, officials had received 50 tons of dopants from China and currently have 10 days of reserves. Moreover, the factory continues to operate regularly, 12 transportation companies are distributing 3000 tons of processed coals by 240 trucks to contracted sale centers. Due to Mongolia closed off the border with China, dopants will be no longer imported to Mongolia. In accordance with the matter, people stocked up enhanced coal briquette and emerged a shortage. Recently, citizens complained that there are processed fuel shortage in ger districts. ■

IT'S NOT HOW MUCH YOU READ. IT'S WHAT YOU READ

READSMART | READRESPONSIBLY | READZGM



Quarter 30,000₮ | Semi-annual 60,000₮ | Annual 120,000₮



GET ZGM SUBSCRIPTION TODAY

Scan the QR code with your mobile bank account to enter e-mail and phone number in the description. Choose your plan and complete the transaction.

Visit the website for more

www.zgm.mn

Утас: 70103131



“Бүх оддын тоглолт” үзэгчдийг уйдаасангүй

Брижес шалгарлаа. Тэр 20 оноо авч, таван удаа самбараас бөмбөг аван, таван оновчтой

дамжуулалт өгчээ.

USA Team 151:131
World Team (30:39, 41:42, 44:24, 36:26)

АНУ: Паскалл (23), Секстон (21), Брижес (20).

Дэлхий: Барретт (27), Кларк (22), Дончич (16), Вагнер (16), Гилжес-Александр (16).

Уг тоглолтын үеэр NBA-д тоглож буй япон залуу Рүй Хачимүра “Залуу оддын тоглолтод оролцсон анхны япон тоглогч болсон нь гайхалтай байлаа. Өөрөөрөө маш их бахархаж байна. Миний бодлоор маш олон япон хүн тоглолтыг маань үзсэн байх. Эх орондоо сагсан бөмбөгийг илүү их хөгжүүлэхийг хүсэж байна. Би япон хүн болж төрснөөрөө бахархаж явдаг” хэмээн ярьжээ.

Уг тоглолтын үеэр NBA-д тоглож буй япон залуу Рүй Хачимүра “Залуу оддын тоглолтод оролцсон анхны япон тоглогч болсон нь гайхалтай байлаа. Өөрөөрөө маш их бахархаж байна. Миний бодлоор маш олон япон хүн тоглолтыг маань үзсэн байх. Эх орондоо сагсан бөмбөгийг илүү их хөгжүүлэхийг хүсэж байна. Би япон хүн болж төрснөөрөө бахархаж явдаг” хэмээн ярьжээ.

Уг тоглолтын үеэр NBA-д тоглож буй япон залуу Рүй Хачимүра “Залуу оддын тоглолтод оролцсон анхны япон тоглогч болсон нь гайхалтай байлаа. Өөрөөрөө маш их бахархаж байна. Миний бодлоор маш олон япон хүн тоглолтыг маань үзсэн байх. Эх орондоо сагсан бөмбөгийг илүү их хөгжүүлэхийг хүсэж байна. Би япон хүн болж төрснөөрөө бахархаж явдаг” хэмээн ярьжээ.

чадаагүй болохоор шүүгчид 50 оноо өгөөгүй байх. Гэхдээ шүүгчид түүнд 48 оноо өгч, биднийг ахин нэг удаа өрсөлдүүлээсэй гэж би найдаж байсан” хэмээн ярьжээ. Харин Такко “Аарон Гордоныг би аварга болсонд итгэсэн. Гэвч шүүгчдийн оноог хараад гайхлаа. Юу болоод өнгөрөв өө” гэжээ. Ямартай ч Жонес төрсөн өдрөөрөө слэм данкийн аварга болсноор өөртөө болон ээждээ том бэлэг барив. Сонирхуулахад, Жонес слэм данкийн тэмцээнд түрүүлсэн

Д.Уэйд 2006, 2007 онд дараалан түрүүлж байжээ. Сагсан бөмбөг сонирхогчдын таамгаар өнгөрсөн жилийн тэмцээний аварга Жэйсон Тэйтум аварга хамгаалах ёстой байлаа. Гэвч тэр хангалттай байсангүй. Мөн 2018 оны аварга Спэнсер Динвийдийг ч харж байв.

Холын зайн шидэлт

Хамгийн сонирхолтой, бас өрсөлдөөнтэй болсон тэмцээн нь холын зайн шидэлтийнх байлаа. Финалд 2018 оны аварга Дэвин Бүүкер, болон Дэвис Бертанс, Бадди Хийлд нар



✎ Б.Мөнхзул, ЗГМ сонин

NBA-ийн 69 дэх “Бүх оддын тоглолт” Чикаго хотын “Юнайтэд центр”-т гурав дахь өдрөө үргэлжилж байна. Алдарт тамирчин Коби Брайантын гэгээн дурсгалд зориулсан гэгдэж буй 2020 оны “Бүх оддын тоглолт” олон зүйлээрээ шинэлэг, бас үзүүштэй байлаа. Тухайлбал, оддын тулаанб MVP-гийн шагналын нэрийг өөрчилж, Коби Брайантын нэрэмжит болгов. Коби Брайант тус шагналыг хамгийн олон буюу дөрвөн удаа хүртэж байв.

Ингээд “Бүх оддын тоглолт”-ын эхний хоёр өдрийн тэмцээнийг тоймлон хүргэе.

АМЕРИКЧУУД ЯЛАЛТ БАЙГУУЛАВ

Эхний өдөр лигийн залуу оддын тоглолт болж, АНУ-ын шигшээ баг Дэлхийн шигшээтэй хүч сорилоо. **Тун сонирхолтой болж өндөрлөсөн тус тоглолтод АНУ-ын баг 151:131-ээр ялалт байгуулав.**

Америкийн багийн Паскалл оноогоор манлайлсан бол Секстон, Брижес нар 20-иос дээш оноогоор тусалжээ. Тэгвэл дэлхийн багаас Барретт 27 оноо авсан бол Кларк 22 оноо нэмэрлэв. Шилдэг тоглогчоор АНУ-ын багийн Майлс



“МАЙАМИ ХИТ”-ИЙН ХОЁР ТОГЛОГЧ ЦОМ ӨРГӨЛӨӨ

“Бүх оддын тоглолт”-ын хоёр дахь өдөр буюу өчигдөр ур чадвар, холын зайн шидэлт, слэм данкийн тэмцээн болсон бөгөөд олны төсөөллөөс өөр дүн гарсан гэхэд болно. Энэ өдөр “Майами Хит”-ийн хоёр тоглогч цом өргөсөн нь тус багийн фэнүүдэд таатай байсан биз.

Слэм данк

Уг тэмцээнд дөрвөн тоглогч оролцсон бөгөөд Дуайт Ховард супермэн дүрээрээ эргэн ирсэн ч залуучуудыг дийлсэнгүй. Тэрбээр “Зүгээр л гайхалтай сайхан мэдрэмж байлаа” гэсэн бол слэм данкийн тэмцээнд хоёр дахь удаагаа финалдаад ялагдсан Аарон Гордон “**Онцгүй зүйл боллоо, оноог минь дараад. Надад хоёр цом байх ёстой юм шиг санагдаж байна**” гэж хэлээд дахин слэм данкийн оролцохгүй гэдгээ мэдэгдлээ. Шүүгчдийн өгсөн оноонд тэр сэтгэл дундуур байгаагаа илэрхийлсэн бөгөөд өөрийгөө уг цомыг зүй ёсоор авах ёстой нэгэн байсан гэдгийг ч нуусангүй. Харин тэмцээний аварга “Майами Хит”-ийн Деррик Жонес Жр “**Тэр Таккогийн толгойг бүрэн давж**

“Майами Хит”-ийн хоёр дахь тоглогч болсон. 1984 оноос эхлэлтэй тус тэмцээнд өмнө нь “Майами Хит”-ээс Хэролд Майнер түрүүлж байсан юм. Тэрбээр 1993 болон 1995 оны аварга. Тэгвэл тэр цагаас хойш 25 жилийн дараа Жонес аварга болж байна.

Ур чадварын тэмцээн

Бас л санаанд оромгүй үр дүн. “Майами Хит”-ийн том залуу Бам Адебайо түрүүлснийхээ дараа “**Том тоглогчид ч бас авьяастай гэдгийг харуулж чадсандаа баяртай байна. Энэ цомоо ээждээ аваачиж өгнө**” хэмээн хэлсэн нь олны сэтгэлийг хөдөлгөв. Тэр ур чадварын тэмцээнд түрүүлсэн “Майами Хит”-ийн хоёр дахь тоглогч болсон. Түүнээс өмнө

тунав. Латвийн лазер тусгалтай Бертанс сүүлийн шатанд хамгийн бага оноо авснаар гуравдугаарт байрт шалгарсан бол Бүүкер энэ лигийн шилдэг шидэгч гэдгээ нотолж аман хүзүүдлээ. Гэхдээ тэр түрүүлсэн Бадди Хийлдээс ердөө ганцхан оноо дутсан.

Харин Бадди Хийлд 27 оноо авснаар цом өргөсөн бөгөөд “Сакраменто Кингс”-ээс холын зайн шидэлтийн тэмцээнд түрүүлсэн хоёр дахь тоглогч болов. Түүнээс өмнө Пежа Стоякович 2002, 2003 онд дараалан аваргалж байсан юм. **Багамын аралд төрсөн Бадди Хийлд шагналынхаа 50 мянган ам.долларыг Дорьян хар салхинд өртсөн хүмүүст зориулахаа мэдэгджээ.** ■

ЭНЭ ӨДРИЙН ЗУРХАЙ

Нумын ордынхон удирдагч гэдгээ харуулна

Хонь /III.21-IV.19/
Өнөөдөр танд ирсэн гэнэтийн мэдээлэл энэ долоо хоногийн төлөвлөгөөнд чинь өөрчлөлт оруулна. Ажлын бус цагт дуртай зүйлээ хийж толгойгоо сэргээхийг илүүд үзнэ. Энэ нь танд нэг ёсны амралт болдог. Хайр дурлал ойлголцол, итгэлцэл дээр тогтож амжилттай байна.

Мэлхий /VI.22-VII.22/
Ер бусын бүтээлч санаа төсөөлж байгаагүй гайхалтай үр дүнг авчирна. Ажлын эрч хүч идэвх зүтгэл, таны хичээнгүй гайхалтай чадвар амжилтыг хөтлөхөд гүүр болно. Таныг амьдралаа эрсдэлд оруулж болохуйц санхүүтэй холбоотой томоохон худалдан авалт хийхгүй байхыг анхааруулж байна. Ажил дээр таатай харилцааг үргэлжлүүлж, хамт олны хүндэтгэлийг хүлээнэ.

Жинлүүр /IX.23-X.22/
Гэнэтийн таагүй зүйлээс болж сэтгэл санаа хямрах байдал үүснэ. Аливаа зүйлийг гүн гүнзгий хүлээж авдаг таны хувьд тайвшралыг хурдан авч чадахгүй л болов уу. Од эрхэс бусад өдрүүдээс илүүтэй энэ өдөр таныг тэвчээртэй, биеэ барихыг зөвлөж байна. Амьдралаа бодитоор харах, хэн нэгнээс халамж мэдрэх хүсэл өөрийн эрхгүй төрөх болно.

Матар /XII.22-I.19/
Хорвоо дээр өнөөдөрөөс өөр өдөр байхгүй мэт, өнөөдөр л сүүлийн өдөр мэтээр хоол цайгаа умартан шаргуу хөдөлмөрлөнө. Үр дүн нь танд аль хэдийн тодорхой болсон тул та сатаарах зүйлгүй. Оюунлаг нэгэнд шинэ санаа, уран бүтээлийн онцгой сэдвүүд ундран гарах болно. Хайр дурлал таны бодсон санаснаар болохгүй л бололтой. Боломж дахиад харамгүй ирэх болно.

Үхэр /IV.20-V.20/
Бодож санаснаа шулуухан хэлчихдэг зангаасаа болж ойрын хүнээ гомдооход хүрнэ. Энэ нь таныг тавгүйтүүлж харилцан эвлэрлийг бий болгох гэж хамаг хүчээ барна. Та бусдаас илүү, би бүгдийг чаддаг гэж эрдэх хэрэггүй. Энэ нь хамт ажиллагсдын дургүйг хүргэж таны ажлын үр дүнд нөлөөлөх болно. Та хүссэн үр дүндээ хүрч чадахгүйд хүрнэ.

Арслан /VII.23-VIII.22/
Өдрийн зарим нэг баримт бичгийг цэгцлэх, удирдах ажилтантайгаа төрийн байгууллагад ямар нэг асуудлаар хандахад тохиромжтой. Гэрээ хэлэлцээр, гарын үсэг зурах зэрэгт таатай. Шийдвэрлэгдээгүй асуудлыг шийдэхэд хамт ажиллагч, ойр дотнын хүмүүс чухал нөлөө үзүүлнэ. Хууран мэхлэлттэй нүүр тулна.

Хилэнц /X.23-XI.22/
Хийж дуусгалгүй үлдээсэн ажлаа дуусгах гэж хичээнэ. Ажил дээр цалин нэмэх, зарим урамшуулал олгох гээд таатай нөхцөл байдал өрнөнө. Худалдаа арилжаа хийдэг хүмүүсийн хувьд энэ өдрүүд орлого өсөн нэмэгдсэн сайхан өдрүүд байх болно. Аз туршсан байдлаар их мөнгөтэй холбоотой ажил төрөл хийх, зээл авахаас зайлсхий.

Хумх /I.20-II.18/
Энэ долоо хоногийн эхний өдөр өөдрөг, баяртайгаар ажлаа эхлэнэ. Хэн нэгэнд амлалт өгч түүнийг биелүүлэхийн төлөө хичээнгүйлэн ажиллах болно. Ажлын ачаалал өндөртэй, цаг хугацаа хэрхэн хурдан өнгөрч байгааг үл анзааран завгүй өдрийг өнгөрүүлнэ. Бүтэхгүй болохгүй байгаа зүйлийг заавал болгох гэж хар муйхраар зүтгэх хэрэггүй.

Хамтатгах /V.21-VI.21/
Таны эрч хүч, энерги хувьсан өөрчлөгдөж янз бүр байх болно. Хийж бүтээсэн, чармайлт гаргасан үйл хэрэг тань бодсон шиг чинь ашиг авчрахгүй нь. Энэ өдөр та ихээхэн мөнгө төгрөгтэй холбоотой наймаа арилжаа хийх, хөрөнгө оруулалт хийх гэсний хэрэггүй. Санаандгүй нэг дор цугларсан найз нөхөд, ойр дотнынхон тань таны амьдралыг гэрэлтүүлэх болно.

Охин /VIII.23-IX.22/
Арга заль хэрэглэж, хууран мэхэлж амжилт олох гэсэн атгаг санаатай нэгний төлөвлөгөө тааруухан байна. Гэвч зарим хүмүүс амжилт олж чадна. Аливаа саад тотгорыг даван гарах эрч хүчийг та хамт ажилладаг дотнын найзаасаа авна. Ойрын төрлийн хэн нэгэн томоохон хэмжээний мөнгөний асуудалд орж танаас тусламж дэмжлэг хүснэ. Гэвч энэ нь тийм ч амар шийдвэрлэгдэх асуудал биш.

Нум /XI.22-XII.21/
Нөхцөл байдлаа бататгах, санаачлагатай мөн зоримог байхыг зөвлөж байна. Таныг хэчнээн хөдөлмөрч хүмүүс хүрээлж байгааг та харах болно. Хувийн амьдралд гэнэтийн мэдээ дуулдана. Энэ нь таны амьдралд тодорхой өөрчлөлт авчрах болно. Дотоод сэтгэлээ сайн сонсож, нөхцөл байдлыг бодитоор мэдэр. Аливаа харилцаанд та цэцэн мэргэн, удирдагчийн шинжийг харуулах болно.

Загас /II.19-III.20/
Таныг ажил дээр чинь хэн нэгэн хуурах болно. Энэ нь хортой биш хоржоонтой эд байх болно. Үүний үр дүнд та ажлын талбарт машин мэт ажиллаж ажлын үр дүнд өндөр байна. Аливаа эелдэг хандлага бүх хүмүүст сайн сайхныг, амжилтыг бэлэглэж чаддаг гэдгийг харуулах болно. Бодол биеллээ олсон мэт та уулзахыг хүсэж, үгүйлж байсан найзтайгаа уулзах болно. Танд баяр баяслыг мэдрүүлэх болно.

ДОРНЫН ЗУРХАЙ

Гэрээ хэлцэл байгуулахад сайн



Наран ургах, шингэх: 07:56-18:16
Барилдлага: Идэр
Шүтэн барилдлага: Хүрэлцэхүй
Суудал: Төмөр

Аргын тооллын 2 сарын 17, Сумъяа гараг. Билгийн тооллын 24, Эрхтний тэнгэрт одтой, цагаан бар өдөр. Өдрийн наран 7:56 цагт мандан, 18:16 цагт жаргана.

Тухайн өдөр морь, нохой жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн. Эл өдөр зөв, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, хараал, жатхыг буцаах, амилуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, тангарагаа буцаахад сайн. Золиг гаргах, бумбын үйл, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ

1		2		3		4		5		6		7		8
						9								
10								11						
12	13	14				15				16		17	18	
				19	20			21	22					
								23						
24												26		

ХӨНДЛӨНГӨӨР:

- Алдарт Наран хонгор азарганы эзэн
- Монголын тамирчдаас олимпын наадмын анхны медалийг хүртсэн бөх, дархан аварга
- Камертон хамтлагийн гишүүн
- Төмөр зэргийг нийлүүлж холбох үйл
- Хувь заяа
- Хужир давс
- Говийн ... (шашны ном)

- Найрын ширээнд заавал байдаг цагаан идээ
- Охиноо хүнтэй суухад дагуул болгон өгөх хөрөнгө
- Хамгийн жижигхэн нохой ... хуа
- Олимпын 4, Дэлхийн 10 удаагийн аварга япон бөх бүсгүй
- Исламын шашны ариун судар
- "Давааны цаана даваа" киноны гол дүр, дарга

ТАШУУГААР:

- Дугуйт тэшүүр
- Коммунист дарангуйлагчаа эхнэртэй нь хамт гудамжинд буу-

дан хороож ардчилсан хувьсгал хийсэн улс

БОСООГООР:

- Флоридын хойгийн зүүн талын бүлэг арал
- Монголд үйлдвэрлэдэг байсан ирисний нэр
- Хүнсэнд хэрэглэгддэг нарийн навчит ногоо
- Монголд үйлдвэрлэдэг газтай ундаа
- Ховч
- Эсрэг дүрээрээ алдаршсан

- жүжигчин, СТА
- Үлээвэр хөгжмийн зэмсэг
- Ухаан муут
- Зэвсэгт хүчин
- Хар тэнгистэй Керлингийн хоолойгоор холбогддог тэнгис
- Шатахуун импортлогч компани
- Дэлхийд алдаршиж буй монгол хамтлагийн урсгал ... рок
- Чадвар

Өмнөх дугаарын хариу 02.14

Ш	А	Х		Д		Х	У	Н
А		Э		А		У		А
Н		Э	С	Г	И	Й		С
Х					И			А
	Б	А	Р	И	М	А	Л	
Б				Р				Р
У		Г	У	А	Н	З		О
Й		У		Н		У		Я
Л	У	У		З		Д	А	Л

ЗГМ: СУДОКУ

8	3			1	6			
				8	3	5	4	
	5			4		9		8
9	7	5			3			
					9		5	1
			6	5				2
		9	3		4	2	7	5
3	2				1			9
5	4	8			7			

Өмнөх дугаарын хариу

8	9	7	4	2	1	5	3	6
4	3	1	5	8	6	9	7	2
2	5	6	9	7	3	8	4	1
9	4	5	3	6	7	2	1	8
6	7	2	8	1	4	3	5	9
3	1	8	2	9	5	4	6	7
1	8	3	6	4	2	7	9	5
5	6	9	7	3	8	6	2	4
7	2	4	1	5	9	1	8	3

Уран зургийн нууцаас

“САЛЬВАДОР МУНДИ” ЛЕОНАРДО ДА ВИНЧИ

Сэргэн мандлын үеийн зохион бүтээгч, агуу сэтгэгч, зураач Леонардо Да Винчигийн бүтээл “Сальвадор Мунди” буюу “Ертөнцийг аврагч” хэмээх бүтээл дэлхийн хамгийн өндөр үнэтэй уран зурагт тооцогддог. Тус зургийг 2017 онд 450.3 сая ам.доллараар Саудын Арабын анхны хунтайж Бадр бин Абдулла худалдан авч байв. Да Винчигийн бурхны зургууд өөртөө хүний шинж чанарыг агуулсан гэдгээрээ бусад зураачийн бүтээлээс ямагт ялгардаг. Жишээлбэл, энэхүү зурагт Христ баруун гараараа загалмайг дүрсэлсэн байгаа нь бүгдийн эзэн хаан гэсэн утгатай бөгөөд үхлийнхээ дараа амилсан төрхийг нь амгалан тайван, хүчирхэг дүрээр илэрхийлсэн байна.



Н.Сийлэн, ЗГМ сонин

Уншигч таны оюун боловсролд хөрөнгө оруулах зорилгоор дэлхийн шилдэг уран зургуудын тухай мэдээлэл бэлтгэлээ. Эдгээр зургийг өдгөө суут бүтээл хэмээн нэрийдэж, үнэ цэн нь хэдэн зуун сая ам.доллараар хэмжигдэж байна. Гэвч урлагийн үнэ цэн мөнгөн өртөгт бус гагцхүү өгч буй таашаал, мэдрэмждээ оршдог билээ.

“ХОЁР ХӨШИГНИЙ ДУНД” ФРИДА КАЛО

Фрида Калогийн бүтээлүүд түүний амьдралын тусгал болж байдгаараа онцлогтой. Тэрбээр энэхүү зургийг 1937 онд Лев Троцкийд зориулан бүтээжээ. 1938 онд Нью-Йоркод зохион байгуулагдсан Фридагийн бие даасан үзэсгэлэнд уг зургийг дэлгэхдээ “Хоёр хөшигний дунд” гэх нэртэйгээр үзүүлсэн аж. Октябрийн хувьсгалын толгойлогчдын нэг, социалист удирдагч Лев Троцкий 1936 онд Зөвлөлт холбоот улсаас цөлөгдөж, Фридагийн нөхөр Диого Риверагийн амьдарч байсан ба энэ хугацаанд Фридатай янаг амрагийн харилцаа үүсгэсэн байна. Зураг дээр Фридагийн баруун гартаа барьж буй захианд “Өөрийн бүхий л зүрх сэтгэлийн хамт уг зургийг 1937 оны арваннэгдүгээр сарын 7-ны өдөр Лев Троцкийд зориулав” гэж бичжээ.



“ХАШГИРААН” ЭДВАРД МУНК

Норвегийн нэрт зураач Эдвард Мунк энэхүү алдарт бүтээлээ 1893 онд зуржээ. Зураач уг бүтээлд Осло хотод нар жаргаж буй агшныг харж буй өөрийн дурсамжаа мөнхөлсөн нь энэ аж. “Хашгираан” бүтээл дөрвөн хувилбартай бөгөөд тэрбээр энэ зургийг сэтгэлийн зовлон шаналлаа бүрэн илэрхийлэхийн тулд олон дахин зурсан гэх таамаг бий. Тухайлбал, зурагт цусан улаан тэнгэр дүрсэлсэн нь түүний сэтгэлийн түгшүүрийг илэрхийлдэг. Өдгөө энэхүү бүтээлийг Норвегийн нийслэл Осло хотын Үндэсний уран зургийн музейд хадгалж байна.



“СУВДАН ЭЭМЭГТЭЙ БҮСГҮЙ” ЙОХАННЕСА ВЕРМЕР

Дэлхийн шилдэг арван уран зургийн нэг болох тус бүтээлийг 1665 онд Голландын зураач Йоханнеса Вермер зуржээ. “Сувдан ээмэгтэй бүсгүй”-г “Голландын Мона Лиза” гэж нэрлэх нь ч бий. Тухайн үед бүсгүйчүүд толгойдоо алчуур зүүдэггүй байсан бөгөөд үүнийг зураачийн нууц тэмдэглэгээ гэж үздэг аж. Йоханнес Вермер бүсгүйг яагаад хөмсөггүй зурсан, энэ бүсгүй хэн болох гээд зурагтай холбоотой олон нууц бий. Бүсгүйг зураачийн хайртай эмэгтэй гэх таамаглал ч байдаг.



ХУУЧНЫ ТАНИЛ

Адтай Хонгор

Засагт ханы Цахиур Төмөрийг боолттой ширнээс сулладаг адтай хүү Хонгорын дүрээр бидний сэтгэлд мөнхөрсөн Л.Галбадрахыг “Хуучны танил” буландаа онцолж байна. Тэрбээр зууны манлай “Тунгалаг тамир” романыг бичсэн, төрийн шагналт зохиолч Ч.Лодойдамба, МУАЖ Ч.Долгорсүрэн нарын хүү бөгөөд кинонд тоглохдоо есөн настай байжээ. Тус дүрийг бүтээхийн тулд тэрбээр ээжтэйгээ хамт бүтэн зуны турш бэлтгэл хийсэн гэдэг. “Хаанаас даа. Эр хүн, эр хүндээ хайртай” гэж хэлээд гүйж оддог адтай Хонгор өдгөө Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад Элчин сайдаар ажиллаж байна.



1970 он

2019 он

